

ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЙЛАН
2017-2018 ОН

Редактор
Эмхэтгэсэн:
Дизайнер:

Агуулга

Удиртгал.....

Нэгдүгээр бүлэг

1. Цаг агаар, уур амьсгалын төлөв байдал, өөрчлөлтийн хандлага

1.1. Цаг агаар, уур амьсгалын

тойм.....

1.2. Байгалийн гамшигт үзэгдэл, түүний өөрчлөлт

1.2.1. Агаар мандлын аюултай

үзэгдэл.....

1.2.2. Усны үер

1.2.3. Ган, зудын байдал

1.2.4. Шороон шуурга

1.2.5. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа

1.2.6. Газар хөдлөл, түүний нөлөө

Хоёрдугаар бүлэг

2. Байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлт

2.1. Газрын нэгдмэл сангийн төлөв байдал

2.2. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, ашиглалт

2.3. Цөлжилтийн төлөв байдал

2.4. Бэлчээрийн төлөв байдал

2.5. Уул уурхайн ашиглалтын үеийн байгаль хамгаалал, нөхөн сэргээлт

2.6. Усны нөөцийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлт

2.6.1. Гадаргын усны нөөц

2.6.2. Газрын доорх усны нөөц

2.6.3. Усны нөөцийн хамгаалалт

2.6.4. Усны нөөцийн ашиглалт

2.7. Ойн нөөцийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлт

2.7.1. Ойн нөөц

2.7.2. Ойн нөөцийн хамгаалалт

2.7.3. Ойн нөхөн сэргээлт

2.8. Байгалийн ургамлын нөөцийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлт

2.8.1. Ургамлын төрөл зүйлийн тархац, хамгааллын арга хэмжээ

2.9. Амьтны нөөцийн хамгаалалт, ашиглалт

2.9.1. Амьтны нөөц

2.9.2. Амьтны ашиглалт

2.9.3. Амьтны хамгаалалт

2.10. Байгаль орчны эсрэг гэмт хэргийн байдал

Гуравдугаар бүлэг

3. Байгаль орчны бохирдол, өөрчлөлтийн төлөв

3.1. Агаарын бохирдол

3.2. Хөрсний бохирдол

3.3. Усны бохирдол

3.4. Хог хаягдал

3.5. Химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ

Дөрөвдүгээр бүлэг

4.1. Салбарын эрх зүйн өнөөгийн байдал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
МУЭЗНХҮЧ	Монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
АЭЗНХҮЧ	Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ИГЧБЦГХЗахиргаа	Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
ТХГазар	Тусгай хамгаалалттай газар
УГГХДТСГЗахиргаа	Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа
УТХГ	Улсын тусгай хамгаалалттай газар
УЦУОШТөв	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
ААН	Аж ахуйн нэгж
АЖХ	Аялал жуулчлалын холбоо
БОНБҮЕД	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ ерөнхий дүгнэлт
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БХНСАХЗ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ОНТ	Орон нутгийн төсөв
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
МБОАБТ	Монголын байгаль орчин, аюулгүй байдлын төв
БОНХС	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар

Удиртгал

Байгаль орчин, аялал жуулчлалын тэргүүлэх чиглэл болох байгаль орчны төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн чиг хандлагыг судлан шинжлэх, байгаль орчныг хамгаалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахтай холбогдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээнд шинжлэх ухааны ололт, ногоон технологи нэвтрүүлэхэд урамшууллын болон зохицуулалтын хөшүүрэг ашиглах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад мэдлэг олгох, байгаль орчны салбарын ажилтан, албан хаагчдад салбарын цаашдын хөгжлийг дээшлүүлэх, олон нийтийг мэдээллээр хангах үүднээс энэхүү тайланг гаргаж анх удаагаа хэвлэмэл байдлаар гаргасан болно. Нийгмийн хөгжлөө дагаад байгаль орчны салбарт болон иргэдийн амьдралд технологийн хөгжлийн нөлөө ихэсч, санхүүгийн боловсрол нэмэгдэхийн хэрээр бодит тоо баримт, судалгаа, шинжилгээ аливаа салбарын цаашдын бодлого төлөвлөлт, чиг хандлага, хөгжилд чухал ач холбогдолтой болоод байна.

Байгаль орчны төлөв байдлын тайланг 2 жилд 1 удаа гаргадаг бөгөөд 2017-2018 оны аймгийн хэмжээний тайланг боловсруулав. Байгаль орчны төлөв байдлыг тайлангийн зорилго нь байгаль орчны одоогийн төлөв байдлыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгч, бодлого төлөвлөгөө боловсруулахад суурь мэдээлэл болох юм.

Тайлангийн 1 дүгээр бүлэгт цаг агаарын төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх сүүлийн жилүүдийн цаг уурын ажиглалтын дэлгэрэнгүй мэдээллийг Ус, цаг уур орчны шинжилгээний төвөөс авч гаргав.

Тайлангийн 2 дугаар бүлэгт байгалийн баялгийн нөөцийн өнөөгийн төлөв байдал, түүний ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн мэдээ, тоо баримтыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Сум дундын ойн анги болон холбогдох тайлангуудаас авч нэгтгэн боловсруулав.


Тайлангийн 3 дугаар бүлэгт байгаль орчны бохирдлын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаарх мэдээ, тоо баримтыг холбогдох судалгаа, шинжилгээний ажил, тайлангуудад үндэслэн нэгтгэн боловсруулав.

Тайлангийн 4 дүгээр бүлэгт байгаль орчны засаглалын өнөөгийн байдал, ногоон хөгжлийн зорилтын талаарх тоо баримт, салбарын эрх зүй, төсөв санхүүгийн холбогдох мэдээлэл болон аялал жуулчлалын талаарх мэдээллийг нэгтгэн тусгав.


Нэгдүгээр бүлэг. Цаг агаар, уур амьсгалын төлөв байдал, өөрчлөлтийн хандлага

1.1 ЦАГ АГААР, УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Агаарын температур. Дундговь аймгийн олон жилийн дунджаар агаарын температур 0.5–4.0 градусын хооронд хэлбэлздэг байна. Агаарын температур дунджаар 2017 онд 2.6 – 6.5 градус, 2018 онд 2.1–5.6 градус байсныг олон жилийн дундажтай харьцуулбал 2017 он 1.0–2.9 градусаар, 2018 он 0.6 –2.6 градусаар дулаан байжээ (Зураг 1). Агаарын жилийн дундаж температурыг дундчилж авч үзвэл 2017 онд 2.4 градус, 2018 онд 1.7 градусаар олон жилийн дунджаас дулаан байжээ(Зураг 2).




Зураг 1. Дундговь аймгийн агаарын жилийн дундаж температур сумдаар /2017, 2018 он/



Зураг 2. Дундговь аймгийн агаарын жилийн дундаж температур /2017, 2018 он/


Жилийн хамгийн хүйтэн агаарын дундаж температур 1 дүгээр сард 2017 онд -14,0...-20,1 градус, 2018 онд -17,2...-21,7 градус хүйтэн байсныг олон жилийн дундажтай харьцуулахад 2017 оны 1 дүгээр сард **Сайхан-Овоо** олон жилийн дунджаас **1,2 градусаар хүйтэн**, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим болон 1,6-2,9 градусаар дулаан, 2018 оны 1 дүгээр сард Дэрэн, Хулд сумдаар олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас **1,2-2,7 градусаар хүйтэн** байлаа(Зураг3).



Зураг 3. Дундговь аймгийн агаарын дундаж


температур /2017, 2018 оны 1 дүгээр сар/

Агаарын хамгийн хүйтэн температур 2017 онд 26 – 34 градус хүйтэн, 30 градусаас хүйтэн нутгийн хойд хэсгээр 1 – 8 өдөр хүйтэрсэн, 2018 онд 30 – 38 градус хүйтэн, 30 градусаас хүйтэн нийт нутгаар 1 – 14 өдөр хүйтэрсэн. (Зураг 4).



Зураг 4. Дундговь аймгийн агаарын хамгийн хүйтэн температур /2017, 2018 он/


Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын агаарын дундаж температур 2017 онд 21,2 – 26,1 градус, 2018 онд 18,9 – 24,0 градус дулаан байсныг олон жилийн дундажтай харьцуулахад 2017 оны 7 дугаар сард **нийт нутгаар олон жилийн дунджаас 1,9 - 5,7 градусаар дулаан**, 2018 оны 7 дугаар сард Мандалговь, Адаацаг, Өлзийт сумдад олон жилийн дунджаас 1,2 - 2,1 градусаар дулаан бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байлаа(Зураг 5).



Зураг 5. Дундговь аймгийн агаарын дундаж температур /2017, 2018 оны 7 дугаар сар/


Үнэмлэхүй хамгийн их температур 2017 оны зуны саруудад 38 – 41 градус хүрч агаарт 30 градусаас дулаан 22 – 52 өдөр халсан, 2018 онд 32 – 36 градус хүрч агаарт 30 градусаас дулаан 12 – 31 өдөр халсан(Зураг 6). 2017 онд Гурвансайхан, Өлзийт сумдад 40 - 41 градус хүрч агаарт 30 градусаас дээш 49 – 52 өдөр халсан

бөгөөд 2017 оны зун хэт халалт ихтэй зун байлаа, 2018 онд Гурвансайхан, Хулд сумдад 36 градус хүрч агаарт 30 градусаас дээш 34 өдөр халсан.




Зураг 6. Дундговь аймгийн агаарын үнэмлэхүй хамгийн их температур /2017, 2018 он/

Хур тунадас. Дундговь аймгийн нутгаар олон жилийн дунджаар 94.9–209.0 мм хур тунадас ордог. 2017 онд нийт нутгаар жилдээ 59.1 – 156.7 мм хур тунадас орсон бөгөөд олон жилийн дунджийн орчим буюу түүнээс бага хур тунадас орсон. 2018 онд 141.5–212.2 мм хур тунадас орсон бөгөөд олон жилийн дунджаас ахиу буюу олон жилийн дунджийн орчим хур тунадас орсон. 2017 онд хур тунадасны хэмжээ буурах хандлагатай байсан ч 2018 онд өсч буй нь харагдаж байна. Энэ нь халалтын улмаар үүсдэг конвекцийн үзэгдлийн нэг болох дуу цахилгаантай аадар бороо орох нь ихэссэн мөн нөгөө талаасаа 2008 оноос цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй шууд холбоотой юм. Жилийн нийлбэр хур тунадасны хэмжээгээрээ хамгийн бага нь 2017 онд Өндөршил суманд 59,1 мм, 2018 онд Баянжаргалан суманд 141,5 мм, хамгийн их нь 2017 онд Дэрэн суманд 156,7 мм, 2018 онд Говь-Угтаал суманд 212,2 мм, Цагаандэлгэр суманд 2017, 2018 онуудад олон жилийн дунджаас бага хур тунадастай байлаа(Зураг 7).




Зураг 7. Дундговь аймгийн жилийн нийлбэр хур тунадас/2017, 2018 он/

Хур тунадасыг 4 – 10 дугаар сар дулааны улирал, 1 – 3 дугаар сар, 11 – 12 дугаар саруудыг хүйтний улирал гэж авч үзвэл дулааны улирлын хур тунадас жилийн нийлбэр хур тунадасны 85-95 хувийг эзэлдэг бөгөөд энэ нь дээр дурьдсанчлан дулааны гаралтай конвекцийн үзэгдлүүд, мөн цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг мөн дулааны улиралд явуулдагтай шууд холбоотой юм. Дулаан улирлын хур тунадас 2017 онд ихнэх нутгаар олон жилийн дунджаас бага, 2018 онд олон жилийн дунджаас ахиу буюу орчим хур тунадас орсон нь харагдаж байна(Зураг 8).



Зураг 8. Дундговь аймгийн дулааны улирлын хур тунадасны нийлбэр /2017, 2018 он/

Харин хүйтэн улирлын хур тунадасны хэмжээ 2017 онд 1,6 – 26,3 мм, 2018 онд 0,7 – 9,2 мм хур тунадастай байжээ, олон жилийн дундажтай харьцуулахад 2017 онд Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Говь-Угтаал, Хулд, Дэлгэрхангай сумдад олон жилийн дунджаас ахиу, бусад сумдаар 2017, 2018 онуудад олон жилийн дунджаас бага хур тунадас оржээ. 2017 оны 3 дугаар сарын 22 – 24-ны өдрүүдэд 1 удаа Дэлгэрхангай 14,7 мм, Сайхан-Овоод 11,8 мм, Хулд суманд 5,5 мм цас орж, шуурч байсан(Зураг 9).




Зураг 9. Дундговь аймгийн хүйтний улирлын хур тунадасны нийлбэр

/2017, 2018 он/

1.2 БАЙГАЛИЙН ГАМШИГТ ҮЗЭГДЭЛ, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ**Хамгийн их учруулсан гамшигт үзэгдлийн тоо**

Дундговь аймгийн хэмжээнд 2018 онд газар хөдлөлт 1 иргэний 1 ханатай гэр нурсан, угалз шороо шуурч, мөндөр орсны улмаас 33 айлын хашаа, 2 автомашины цонх, 2 байшингийн дээвэр, 4 айлын гэр нурж, цахилгаан хуваарилах самбар эвдрэлд орсон.

Хүчтэй салхи. Улс ардын аж ахуйд нөлөө бүхий уур амьсгалын үзүүлэлтийн нэг нь хүчтэй салхи түүнтэй холбогдох үзэгдэл юм. 2017, 2018 онд хүчтэй салхитай өдрийн тоог авч үзвэл Мандалговь, Гурвансайхан, Говь-Угтаал өртөөнд хамгийн их салхилдаг. 2017, 2018 оны мэдээгээр сүүлийн жилд өсч байгаа нь харагдаж байна. Хамгийн их тохиолдол нь 2018 онд Гурвансайхан, Говь-Угтаалд 50 – 51 тохиолдол ажиглагдсан бол хамгийн бага нь 2017 онд Адаацаг, Хулд, Дэлгэрхангай сумдад 2 - 3 тохиолдол бүртгэгджээ(Зураг 11).




Зураг 11. Дундговь аймагт хүчтэй салхитай өдрийн тоо /2017, 2018 он/

Хүчтэй салхины хамгийн их хурд 2017 онд Цагаандэлгэр суманд 28 м/секунд, 2018 онд Говь-Угтаал суманд 29 м/секунд хүрч салхилж байжээ.


Шороон болон цасан шуурга. Харин шороон шуургатай өдрийн тоо 2018 онд өссөн. 2017 онд 3 – 28 удаа, 2018 онд 9 - 41 удаагийн тохиолдол бүртгэгдсэн бол хамгийн их нь 2018 онд Мандалговь, Гурвансайхан сумдад 41 удаа шороо шуурчээ. Шороон шуургатай өдрийн тоо 2018 онд 6 – 13 нэмэгджээ. Цасан шуурга 2017 онд 3 – 20 удаа, 2018 онд 2 – 26 удаа ажиглагджээ(Зураг 12).

2018 оны 4 дүгээр сарын 04, 05-нд Сайхан-Овоо, Дэлгэрхангай сумдаар 14 м/секунд, бусад сумдаар 18-20 м/секунд зарим үед 20 - 28 м/секунд хүрч хүчтэй салхилж, хүчтэй цасан болон шороон шуургатай тааламжгүй байлаа. Цаг агаарын аюултай үзэгдлээс болж 9 сумын 11205 толгой мал хорогдож, ЭДЦСургуулийн дотуур байрны дээвэр хуурсан.



Зураг 12. Шороон болон цасан шүүргатай өдрийн тоо /2017, 2018 он/

Аадар бороо. Сүүлийн үед босоо хөгжлийн хүчтэй хөгжсөн борооны бөөн үүлний дор аянга дуу цахилгаан, аадар бороо, нөөлөг салхи асар богино хугацаанд ард иргэд аж ахуй нэгжид хохирол учруулах нь их болсон(Зураг 13). 2018 онд хур тунадас ахиу орсон, аадар тунадастай өдрийн тоо огцом 9 - 42-оор нэмэгдсэн.



Зураг 13. Аадар бороотой өдрийн тоо өртөөдөөр /2017, 2018 он/

Мөндөр. Дундговь аймгийн 2017 оны 7 дугаар сарын 25-нд Эрдэнэдалай сумын төвд 14 мм голчтой мөндөр 9 минут үргэлжлэн орсноос эрчим хүчний 1 шон, утасны 1 шон унасан, эрчим хүчний 28 шон тулгуур нь хазайсан ард иргэдэд 250 мянган төгрөгний хохирол учирсан.

Сайнцагаан суманд 8 дугаар сарын 9-нд 15 цаг 11 минутаас эхэлж 8 минутын хугацаанд 21 мм голчтой мөндөр, 1 цаг 21 минутын хугацаанд 10 мм аадар бороо орсон. Аадар бороо ширүүн, шуургалан орсон учраас газарт шингэлгүй гуу жалга, засмал замаар ихээхэн хэмжээний ус урслаа.

Сайнцагаан сумын Наран багийн нэг айлын гэр нурсан, Нарлаг багийн 2 айлын хашаанд их хэмжээний ус хуримтлагдаж гэр, хашаа усанд автсан, аймгаас баруун тийш байрлах амралтын газрын байшингийн хойд болон баруун талын цонхнууд хагарсан, Хүүхдийн сувилалын 4 гэрийн бүрээс, 1 байшингийн гадна пассад мөндөрт цохигдож ашиглах боломжгүй болсон, **Эрүүл мэндийн зоорь үерийн ус**


дүүрч ОБГ, ЭМГ, “Дундговь-Ус” ОНӨҮГ-ийн ажилчид хамтран усыг зайлуулах арга хэмжээг авч ажилласан.

2018 оны 7 дугаар сарын 7-нд Дэлгэрхангай сумын төвөөс хойш 1 км газарт 2-6 см голчтой хонины хорголоос, тахианы өндөгний чинээ мөндөр 1 км орчим зурвас газарт 7 минут үргэлжлэн орсноос байшингийн шил, машины цонх хагарч, айлын гэрийн бүрээс урагдсан хохирол учирсан.


8 дугаар сарын 8-9-ны шилжих шөнө Өндөршил сумаас БӨ зүгт 30 км-т мөндөр орсноос, айлын гэрийн бүрээс урагдаж, бага мал хорогдсон.



Цасан бүрхүүл. 2017 оны 01 дүгээр сард зарим нутгаар буюу зүүн захаар Цагаандэлгэр, Өндөршил, баруун зах Сайхан-Овоо сумдад 3 см зузаан $0,26 \text{ г/см}^3$ нягттай, 9-10 баллын цастай, Дэлгэрхангай, Говь-Угтаал, Гурвансайхан, Адаацагт баруунаас бусад зүгт 5-9 баллын цастай, бусад нутгаар 1-4 баллын мөстсөн цастай байлаа. 02 дугаар сарын 28-ны байдлаар Сайхан-Овоо суманд 5 см дундаж зузаантай, $0,20 \text{ г/см}^3$ нягттай, 5-9 баллын мөстсөн цастай, Цагаандэлгэр, Гурвансайхан, Говь-Угтаал сумдад 1-2 см зузаантай, битүү 10 баллын сэвсгэр цастай, Мандалговь, Адаацаг, Баянжаргалан, Дэрэн, Өлзийт сумдад 0-1 см зузаантай, 5-9 баллын мөстсөн цастай, бусад нутгаар 1-4 баллын цастай буюу өдөртөө дулаарч цас хайлж тарлантсан. Өндөршил суманд цас хайлж цасгүй болсон. 03 дугаар сарын эхний 10 хоногийн байдлаар нийт нутгаар цасгүй болсон. 2017 оны **11 дүгээр** сарын 30-ны өдрийн байдлаар цасан бүрхүүлийн хувьд Цагаандэлгэр суманд 2 см зузаантай, 10 баллын мөстсөн цастай, Сайхан-Овоо, Говь-Угтаал, Дэрэн, Баянжаргалан Дэлгэрхангай, Луус, Адаацаг, Эрдэнэдалай сумдад 1-4 баллын мөстсөн цастай, бусад нутгаар цасгүй байна. **12 дугаар сард** Цагаандэлгэр суманд 1 см зузаантай, битүү 10 балл, Мандалговь, Эрдэнэдалай, Говь-Угтаал, Адаацаг, Дэрэн сумдад 0-1 см зузаантай 5-9 баллын шуурсан цастай, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Луус сумдад 1-4 баллын мөстсөн цастай, нутгийн өмнөд хэсгээр цасгүй байна. 2018 оны **01 дүгээр сард** Хулд, Говь-Угтаал, Дэрэн сумдад 1-4 баллын мөстсөн цастай, бусад нутгаар 1-4 см дундаж зузаантай 5-9 баллын мөстсөн цастай. **02 дугаар сарын** 28-ны байдлаар Гурвансайхан, Мандалговь, Эрдэнэдалай, Баянжаргалан, Дэлгэрхангай сумдад 0-1 см зузаантай 5-9 баллын мөстсөн цастай, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Адаацаг, Дэрэн сумдад 0-2 см зузаантай 10 баллын сэвсгэр цастай, Луус, Хулд сумдад 1-4 баллын мөстсөн цастай. Сайхан-Овоо, Өлзийт, Өндөршил сумдад цасгүй. **03 дугаар** сарын эхний 10 хоногт нийт нутгаар цасгүй болсон. Өвөлжилт хэвийн, цас багатай байсан боловч гадны хангайн аймгуудаас отор нүүдэл их ирснээс туурайн зуд болсон (Зураг 14).



2017 оны 1-р сарын 20-нд





2018 он 01-р сарын 20-нд


Зураг 14. Дундговь аймагт 2017, 2018 оны 1 дүгээр сарын 20-ны байдлаар цасан бүрхүүл

1.2.5 Цаг агаарт зориудаар нөлөөлсөн байдал


2017 оны 5 сарын 20-ноос 8 сарын 3-ыг хүртэлх хугацаанд хөрсний чийг нэмэгдүүлэх зорилгоор, 2018 онд 4 сарын 21-нээс 7 сарын 15-ныг хүртэл “МАНДАЛ БОРОО-1” экспедицийн ЦАЗНөлөөлсөн.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагааг хур тунадас орох магадлалтай борооны давхраат үүл услэг ихтэй үед үйлчилдэг. 2017, 2018 оны зун хур тунадас нэмэгдүүлсэн үеийн тархалтын зарим нэгийг зураглал харуулбал(Зураг 10, 11).





Зураг 10. Дундговь аймгийн нутгаар Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлсэн тархалтын зураглал /2017 он/



Зураг 10. Дундговь аймгийн нутгаар Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлсэн тархалтын зураглал /2018 он/

2017 онд ЦАЗНөлөөлж хур тунадас 2,2 – 53,5 мм буюу дулааны улиралд орсон хур тунадасыг 23,2 хувиар нэмэгдүүлсэн, 2018 онд 7 – 25,4 мм буюу 9,2 хувиар нэмэгдүүлсэн.

/Тус бүлгийг аймгийн УЦУОШТөвийн ЦУОТХэлтэс ХААЦУ-ын инженер Б. Болортуяа бэлтгэв./

2. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

2.1. Газрын нэгдмэл сангийн төлөв байдал

Дундговь аймгийн газрын нэгдмэл санд 2018 оны жилийн эцсийн байдлаар хөдөө аж ахуйн газар 7017208.9 га, хот тосгон бусад суурин газар 19661.10 га, зам шугам сүлжээний газар 31984.66 га, ойн сан бүхий газар 32759 га, усны сан бүхий газар 7796 га, улсын тусгай хэрэгцээний газар 391607 га талбайг тус тус эзэлж байна.



Газрын нэгдмэл сангийн 2018 оны тайланг 2017 оны тайлантай харьцуулахад хөдөө аж ахуйн газар, хот тосгон, бусад суурины газар, зам, шугам сүлжээний газар, тусгай хамгаалалттай газар, усны сан бүхий газар, ойн сан бүхий газар онцын өөрчлөлт ороогүй байна.

Аймгийн газрын нэгдмэл сангийн ангилал /мянга.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2017	2018	Зөрүү
	Хөдөө аж ахуйн газар	6951581.36	6949760.69	-6.2
1	Бэлчээрийн газар	6947599.14	6945645.5	-1.9
2	Хадлангийн талбай	-		
3	Тариалангийн талбай	701.32	703.29	1.97
4	Атаршсан газар			
5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	3267.90	3398.90	131


6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	13	13	0
	Хот, тосгон бусад суурины газар	18563.57	19661.10	1097.53
7	Барилга байгууламжийн дэвсгэр газар	370.10	377.77	7.67
8	Нийтийн эдэлбэр газар	7760.60	7500.05	-260.55
9	Үйлдвэрийн газар	30	30	0
10	Уурхайн газар	9125.35	10267.86	1142.51
11	Гэр хорооллын газар	1277.5	1485.42	207.92
	Зам шугам сүлжээний газар	31265.74	31984.66	718.92
12	Авто замын газар	25731.8	25731.8	0
13	Төмөр замын газар	846.3	480	-366.3
14	Агаарын тээврийн газар	46.7	46.7	0
15	Шугам сүлжээний газар	4640.944	5726.16	1085.2
16	Усан тээврийн буудлын газар	-	-	0
	Ойн сан бүхий газар	32759	32759	0
17	Ой модоор бүрхэгдсэн газар	16852	16852	0
18	Ой модыг нь огтолсон газар			
19	Мод үржүүлгийн газар			
20	Ой тэлэн ургах нөөц газар			
21	Ойн сангийн бусад газар	15907	15907	0
	Усны сан бүхий газар	7796	7796	0
22	Гол мөрний эзлэх газар	48	48	0
23	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	7467.5	7467.5	0
24	Горхи, булаг, шандны эзлэх газар	280.5	280.5	0
25	Мөнх цаст, мөсөн голын эзлэх газар	-	-	-
	Улсын тусгай хэрэгцээний газар	427066.33	427070.55	4.22
26	Улсын тусгай хамгаалалттай газар	426413	426413	0
27	Улсын хилийн зурвасын газар	-	-	-
28	Улсын батлан хамгаалах зориулалтын газар	639.03	639.03	0
29	Гадаадын дипломат, консул, төлөөлөгчийн газар	-		-
30	ШУ, туршилт, цаг уурын ажиглалтын талбай	14.3	18.52	4.22
31	Аймаг дундын отрын бэлчээр	-	-	-
32	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	-	-	-

33	Газрын тосны гэрээт талбай	-	-	-
34	Чөлөөт бүсийн газар	-	-	-
Нийт дүн		7469032.00	7469032.00	

2.2. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, ашиглалт Тусгай хамгаалалттай газрын ерөнхий мэдээлэл

2022 оны байдлаар Дундговь аймагт 4 улсын тусгай хамгаалалттай газар, 18 аймгийн тусгай хамгаалалттай газар, 216 сумын тусгай хамгаалалттай газар байгаа бөгөөд нийт газар нутгийн 26 хувийг эзэлж байна. График 1-т тусгав.

График 1



2019 оны байдлаар улс, аймгийн тусгай хамгаалалттай газарт 8 байгаль хамгаалагч ажиллаж байна.

2.2.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг


Дундговь аймагт улсын тусгай хамгаалалттай 4 газар байна. 1996 онд Загийн усны хоолой, 2011 онд Бага газрын чулуу, Дэлгэрхангай уул, 2012 онд Их газрын чулууг тус тус улсын тусгай хамгаалалтад авав. (Хүснэгт 1)

Хүснэгт 1 Улсын тусгай хамгаалалттай газрын ерөнхий мэдээлэл

Д/д	Сумын нэр	Газрын нэр	УИХ-ын тогтоолын огноо, дугаар	Талбайн га		Ангилал	Тайлбар
				Нийт талбай	Эзлэх хувь		
1.	Өлзийт	Загийн усны хоолой	1996.5.7 №43	189465	12,29	Байгалийн нөөц газар	Хужир мараа, заган ой, шал тойром, довцог, элсэн манхан хослон оршдог экологийн өвөрмөц орчин, хар сүүлт цагаан зээрийн тархалтын баруун хойт хязгаар

2.	Говь-Угтаал, Гурван сайхан	Их газрын чулууны уул	2012. 5.23 №57	175906	26,05	Байгалийн цогцолборт газар	Ховор ан амьтан, ургамалтай, байгалийн өвөрмөц тогтоцтой, үзэсгэлэнт газар
3.	Дэлгэр цогт	Бага газрын чулуу	2011.01.20 №04	2718	1.09	Байгалийн дурсгалт газар	Ховор ан амьтан, байгалийн өвөрмөц тогтоцтой, үзэсгэлэнт газар
4.	Дэлгэр хангай	Дэлгэрхангай уул	2011.01.20 №04	58324	9.39	Байгалийн нөөц газар	Ховор ан амьтан, ургамалтай, байгалийн үзэсгэлэнт газар
Нийт				426413			

Улсын тусгай хамгаалалттай газрын ангилал



Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу дархан цаазат газар болон байгалийн цогцолборт газрууд нь хамгаалалтын захиргаатай байна гэж заасны дагуу Дундговь аймгийн Их газрын чулуу байгалийн цогцолборт газрыг хариуцан хамгаалалтын захиргаа ажиллаж байна.

Их газрын чулууны БЦГ


Байгалийн үзэсгэлэн, ландшафтын иж бүрдлийг хамгаалах зорилгоор 2003 онд Засгийн газрын тогтоолоор улсын тусгай хамгаалалтанд авсан юм. Улмаар 2012 онд УИХ-ын 57 дугаар тогтоолоор Их газрын чулууны байгалийн нөөц газрыг байгалийн цогцолборт газар болгон нийт 175,906 га талбайг өргөтгөж ангиллыг дээшлүүлсэн байна.

Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А-06 дугаар тушаалаар батлагдсан "Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадын бүтэц, орон тооны жишиг болон сургалт, мэдээллийн төвүүдийн байршлыг батлах тухай" тушаал гарч Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа байгуулагдсан.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Б-55 тоот тушаалаар даргыг томилсноор үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь үндсэн 10 ажилтан үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгалийн цогцолборт газрын дотоод бүсчлэл



Ландшафт

Зүүн уртрагийн 107 хэм 13%, хойд өргөргийн 45 хэм 48%-д Говь-Угтаал, Гурвансайхан сумын нутгийн уулзварт уртаараа 30 орчим, өргөөшөө 15 км сунаж тогтсон 600 шахам ам км талбайг эзлэн хойшоо, урагшаа, баруун, зүүн тийшээ гудамжлан эгнэсэн, далайн түвшнээс 1565-1709 метр өргөгдсөн боржин, асгалжин, толбожин гэх мэтийн гүний чулуулаг, пермь, цэрд, гурав дахь галвын элсэн чулуу, нүүрслэг занар, алаг мөлгөр хөрзөн, шохойн чулуунаас тогтсон хад байцсын чуулга юм.

Байгалийн цогцолборт газарт цагаан зээр, бор туулай, алаг даага, хонин гүрвэл, огдой, монгол тарвага, үнэг, чоно зэрэг хөхтөн амьтнаас гадна олон улсын хэмжээнд ховордсон, устаж болзошгүй эмзэг амьтны зэрэглэлд орсон аргаль хонь, янгир ямаа нутагладаг. Алаг даага, хадны борогчин, монгол чичүүл зэрэг мэрэгчид, сахалт багваахай, жижиг соотон багваахай зэрэг гар далавчтан, тас, бүргэд, харцага, ногтруу, хээрийн тагтаа, болжмор зэрэг жигүүртэн, аргаль, янгир, шилүүс, үнэг, хярс, тарвага, туулай, зээр зэрэг 20 гаруй төрлийн ан амьтан амьдрана. Нөмрөг тас, Ооч ёл, Хээрийн бүргэд, Элээ, Начин шонхор, ногтруу, сахиа зэрэг шувуу бүртгэгдсэн.

Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт 34 овог, 97 төрөл, 152 зүйлийн ургамалтай. Мөн монгол орны улаан номонд цөлийн аргамжинцэцэг, ноосон шилбэт баглуур 2 зүйл нэн ховор ургамал, пржевальскийн зээргэнэ, анхил

сонгино, ацан ажигана, өргөст ортууз, дагуур хүж өвс, сибирь ерөндгөнө, шаргал шарилж 7 зүйл ховор ургамал ургана.

Их газрын чулууны ууланд “Төв боржигон” жуулчны бааз 5-10 дугаар сард үйл ажиллагаа явуулдаг.

2.2.2. Аймгийн тусгай хамгаалалттай газар нутаг

Дундговь аймагт аймгийн тусгай хамгаалалттай 18 газар 171453.83 га талбайг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд Өлзийт, Сайхан-Овоо, Сайнцагаан сумд аймгийн тусгай хамгаалалтад түүх соёлын дурсгалт, байгалийн өвөрмөц тогтоц бүхий газруудаа оруулсан.

Хүснэгт 2

№	Сумын нэр	Газрын нэр	Ангилал	Талбай н хэмжээ га	Тусгай хамгаалалтад авсан зорилго	Хугацаа жил
1	Адаацаг	Сүм хөх бүрд	Байгаль түүхийн дурсгалт газар	548.5	Түүх соёлын дурсгалыг хамгаалах, байгалийн өвөрмөц тогтцыг хадгалах, аялал жуулчлал хөгжүүлэх	15
2	Өлзийт	Цагаан суварга	Байгалийн нөөц газар	2290.6	Байгалийн өвөрмөц тогтцыг хадгалах, аялал жуулчлал хөгжүүлэх	15
3	Өлзийт	Өөш манхан	Байгалийн нөөц газар	11810.0	Байгалийн өвөрмөц тогтцыг хадгалах, эмчилгээний сувилал, аялал жуулчлал хөгжүүлэх	15
4	Өлзийт	Дэл уулын орчим	Түүхийн дурсгалт газар	24814.6	Түүх соёлын дурсгалыг хамгаалах	15
5	Өлзийт	Хөнжлийн уулын орчим	Түүхийн дурсгалт газар	25871.6	Түүх соёлын дурсгалыг хамгаалах	15
6	Баянжаргалан	Аргын хад	Түүхийн дурсгалт газар	6871.2	Байгалийн өвөрмөц тогтоц, ан амьтан /аргаль, янгир, тарвага/-ыг хамгаалах	15
7	Баянжаргалан	Хүрэн дух	Түүхийн дурсгалт газар	9561.1	Палеонтологийн олдворыг хамгаалах	15
8	Сайхан-Овоо	Онгийн хийд	Байгаль түүхийн дурсгалт газар	6839.6	Түүх соёлын дурсгалыг хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх	15
9	Эрдэнэд алай	Үнэстийн хийд	Түүхийн дурсгалт газар	100.0	Түүх соёлын дурсгалыг хамгаалах	15
10	Сайнцагаан	Олгойн говь 1, 2 –р хэсэг	Усны нөөц газар	7221.0	Аймгийн төвийн усан хангамжийн эх үүсвэрийн газрын доорхи усны гадаад дотоод тэжээгдлийн мужийг хамгаалах	30
11	Гурвансайхан	Ярхын уул	Түүхийн дурсгалт газар	7500.0	Түүх, соёлын дурсгалыг хамгаалах	15

12	Өлзийт	Муруй уул	Ургамлын нөөц газар	1366.0	Заган ойг хамгаалах	15
13	Эрдэнэд алай Сайхан-Овоо Дэлгэрхангай	Дундын нуруу орчмын газар	Сум дундын отрын нөөц /ургамлын нөөц/ газар	5651.1	Отрын бэлчээр хамгаалах	30
14	Баянжаргалан	Их эрээн	Түүхийн дурсгалт газар	9578.3	Түүх соёлын дурсгалыг хамгаалах	15
15	Сайнцагаан	Суман хайрхан, Тогоогийн рашаан	Байгаль түүхийн дурсгалт газар	49000	Түүх соёлын дурсгалыг хамгаалах, байгалийн өвөрмөц тогтцыг хадгалах, ан амьтныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх	15
16	Сайнцагаан	Тэвшийн уул	Түүхийн дурсгалт газар	686.4	Хүннүгийн үеийн булш, бунхан, хиргэсүүр	15
17	Сайхан-овоо	Төгрөг хайрхан уул	Түүхийн дурсгалт газар	572.03	Түүх соёлын дурсгалт/хирэгсүүртэй/, байгалийн өвөрмөц тогтоц бүхий тахилгат уулын экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байх	15
18	Сайхан-овоо	Харганы шугуй	Түүхийн дурсгалт газар	1171.8	Түүх соёлын дурсгалт, байгалийн өвөрмөц тогтоц бүхий шугуйн экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байх.	15
	Талбайн хэмжээ			171453.83		


Хүснэгт 3 БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧТАЙ УЛС, АЙМГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

№	Сумын нэр	Хариуцдаг газрын нэр	Хариуцсан талбай га
1	Дэлгэрцогт	Бага газрын чулууны уул, сүм хөх бүрд орчмын байгаль хамгаалагч	59830
2	Дэлгэрхангай	Дэлгэрхангай уул орчмын байгаль хамгаалагч	173400
3	Өлзийт	Загийн ус орчмын байгаль хамгаалагч	171800
4	Баянжаргалан	Аргын хад, Хүрэн дух, Эрээн орчмын байгаль хамгаалагч	181400
5	Гурвансайхан	Уул-Гурвансайхан орчмын байгаль хамгаалагч	146600
6	Сайнцагаан	Суман хайрхан, Тогоогийн рашаан орчмын байгаль хамгаалагч	186540
7	Өлзийт	Дэл уул, Цагаан суварга орчмын байгаль хамгаалагч Хөнжлийн уул	186300 28800
8	Сайхан-Овоо	Онги гол, Хийдийн уул орчмын байгаль хамгаалагч	173400

Сумын тусгай хамгаалалттай газар нутаг

Дундговь аймагт Сумын тусгай хамгаалалттай 216 газар байна.

График 2



2.3. Цөлжилтийн өнөөгийн байдал.


Уур амьсгалын хэт дулааралт, хур тунадасны бууралт, шороон шуурга болон хүчтэй салхины давтагдал нэмэгдсэн зэрэг байгаль цаг уурын таагүй нөхцлүүд бэлчээрийн талхалдал, авто, зам ашигт малтмал олборлох, хайгуул зэрэг нь бэлчээрийн газар нутгийг, ургамлан нөмрөгийг ядууруулж, цөлжилтөд өртөх нөхцлийг бүрдүүлсэн байна. Сүүлийн жилүүдэд аймгийн нийт нутаг дэвсгэрт ган болж, үүний давтамж, хурц нартай өдрийн тоо жил бүр нэмэгдэж, мөн хүчтэй шороон шуурга, салхитай хоногийн тоо нэмэгдэж, мэргэжлийн байгууллагаас хийсэн дүгнэлтээр бэлчээрийн ургамлын хэмжээ, төрөл сүүлийн 10 жилд 30 хувиар буурчээ.

Тус аймгийн нийт нутаг цөлжилтөд хамрагдаж, нутаг дэвсгэрийн 70 орчим хувийг эзлээд байна. Цөлжилтийн аюулын зэрэглэл нэмэгдэж, өнөөгийн байдлаар Дундговь аймаг хүчтэй зэрэглэлд хамрагдах болжээ.


Газар нутгийн цөлжилтийн зэргээр 0,9%-д цөлжилт илрээгүй, 25,5%-д сул, 45,6%-д дунд, 13,7%-д хүчтэй, 14,2%-д нэн хүчтэй байна.



цөлжилтын эзлэх хувь



/Том зурган дээрээс татаж харуулах/




2017.04.18

2.4 БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


Зуншлага. 2017 онд зуншлагын байдал 05 дугаар сард нийт нутгийн 10% хэвийн, 70% нь дунд зэрэг, 20% орчим нь муу, 06 дугаар сард нийт нутгийн 10% орчим хэвийн, нийт нутгийн 60% гаруй дунд зэрэг, 30% муу байсан. 07 дугаар сарын эхний 10 хоногт нийт нутгийн 5% орчим хэвийн, Дэрэн, Баянжаргалан, Луус, Хулд, Дэлгэрхангай сумдын нутгаар муу буюу нийт нутгийн 35 гаруй хувь, бусад нутгаар дунд зэрэг буюу нийт нутгийн 60 гаруй хувь байснаа 2, 3 дугаар 10 хоногт хур тунадас орсноор Өндөршил, Өлзийт, Хулд, Луус, Сайхан-Овоогийн баруун, зүүн зүг, Цагаандэлгэр сумдад хэвийн буюу нийт нутгийн 40 орчим хувь, бусад нутгаар дунд зэрэг буюу нийт нутгийн 60 гаруй хувь болж сайжирсан. 08 дугаар сарын дунд 10 хоногийн байдлаар зуншлагын байдал нийт нутгийн 60 хувь нь хэвийн, 40 хувь дунд зэрэг болж сайжирсан. 7 сард болон 8 сарын эхэн болон дунд 10 хоногт ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим буюу олон жилийн дунджаас ахиу хур тунадас орсон учир бэлчээрийн ургамлын гарц сайжирч таана дийлэнх хувийг эзэлж байна(Зураг 15).

2018 онд бэлчээрийн ургамал хаврын сүүлч гэхэд нийт нутгийн дөнгөж 10 хувьд буюу Дэлгэрхангай, Гурвансайхан сумын баруун, хойд тал дунд, бусад нутгаар 90 хувьд муу үнэлгээтэй байсан. 6 дугаар сарын сүүлч гэхэд төдийлөн сайжраагүй аймгийн нийт нутгаар муу байсан бол зуншлагын байдал 7 дугаар сарын 10 байдлаар Сайхан-Овоо суманд буюу 10 орчим хувьд дунд, бусад нутгаар 90 хувьд муу байсан. 20-ны байдлаар нийт нутгийн 5 орчим хувьд **хэвийн**, 60 орчим хувьд дунд, 35 орчим хувьд муу үнэлгээтэй байв. Харин 7 дугаар сарын 31-ны байдлаар нийт нутгийн 25 хувьд **хэвийн**, 60 хувьд дунд, 15 хувьд зуншлага муу үнэлгээтэй байж, 7 дугаар сарын 2, 3 дугаар арав хоногт зуншлага сайжирсан. 8 дугаар сарын сүүлчээр аймгийн нийт нутгийн 75 хувьд **хэвийн**, 25 хувьд буюу Дэрэн, Луус сумдын баруун зүг, Сайнцагаан, Эрдэнэдалай, Говь-Угтаал, Хулд сумын хойд зүг дунд үнэлгээтэй байсан(Зураг 15).




2017 оны 5-р сарын 31-ний байдлаар

2018 оны 5-р сарын 31-ний




2017 оны 6-р сарын 30-ны байдлаар


2018 оны 6-р сарын 30-ны байдлаар




2017 оны 7-р сарын 31-ний байдлаар



2018 оны 7-р сарын 31-ний байдлаар




2017 оны 8-р сарын 31-ний байдлаар





2018 оны 8-р сарын 31-ний байдлаар

Зураг 15. Бэлчээрийн ургамлын ургалтын байдал
(2017, 2018 оны 5 - 8 сарын 31-ний байдлаар)

2017 оны 8-р сарын 2-р 10 хоногийн ургамалжилтын төлөв байдал





БЭЛЧЭЭРИЙН ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ ТЭМЦСЭН байдал

2018 онд бэлчээрийн хөнөөлт мэрэгчдийн тархалт, олшролыг тодотгох судалгааны ажлыг аймгийн 7 суманд хийж гүйцэтгэсэн судалгааны дүнгээр бэлчээрийн хөнөөлт мэрэгч болох цайвар үлийчийн голомт бүхий бүх сумдад тархсан бөгөөд нягтралын хувьд хэт олшролын шатандаа орсон учраас механик биологийн аргыг микробиологийн аргатай хослон хэрэглэх шаардлагатай гэсэн дүгнэлтийг гаргасан. Үүний дагуу үлийн цагаан оготны голомт бүхий 8 суманд улсын

төсвийн хөрөнгө оруулалтын 80,0 сая төгрөгөөр 50 мян.га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар, аймгийн ОНХСангийн 36.0 сая төгрөгөөр 7 суманд 22.5 мян.га бэлчээрт микробиологийн аргаар тэмцэх ажлыг үр дүнтэй зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд гүйцэтгэсэн техникийн ажлын үр дүн 84 хувьтай үр дүнтэйгээр дүгнэгдсэн.



2017-2018 ОН

Бэлчээрийн үлийн цагаан оготонотой энгийн механик аргаар тэмцэх арга хэмжээ хийгдэх сумд, тэмцэх талбайн хуваарь 2017-2018 он

Д/д	Сумдын нэр	2017 онд талбайн мян/га	/Тэмцэх хэмжээ	2018 онд талбайн мян/га	/Тэмцэх хэмжээ
1	Эрдэнэдалай	10,0		10,0	
2	Адаацаг	4,0		10,0	
3	Дэлгэрцогт	3,0		10,0	
4	Дэрэн	4,0		17,0	
5	Цагаандэлгэр	4,0		4,0	


6	Говь-Угтаал	9,0	3,5
7	Луус	2,0	
8	Өндөршил	2,0	
9	Сайнцагаан	2,0	4,0
10	Сайхан-Овоо		1,0
	Нийт	9 суманд 40,0	8 суманд 72,5

Өвөл, хаврын бэлчээрийн даац Монгол улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд 2017-2018, 2018-2019 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн багийн нутгаар тооцоолж гаргадаг.

Дундговь аймгийн дүнгээр 2017-2018 оны өвөл, хаврын бэлчээрийн даац 35 орчим хувь бэлчээрийн нөөцтэй, 25 гаруй хувь бэлчээр хүрэлцээтэй учир мал өвөлжилт хаваржилт хэвийн байх боломжтой, харин нутгийн 30 хувь нь өөрийн сумын нутагт мал сүргээ онд оруулах бэлчээрийн боломж муу гарсан.

Адаацгийн хойд болон төв хэсэг, Дэлгэрхангай зүүн хойд хэсэг буюу нийт нутгийн 5 хувь бэлчээрийн даац **олон дахин хэтэрч** гарсан, **Гурвансайханы зүүн хэсэг, Говь-Угтаалын зүүн тал, Адаацгийн урд тал, Эрдэнэдалайн хойд, өмнө, зүүн хойд, зүүн урд, урд тал, Сайхан-Овоогийн зүүн хойд тал, Дэлгэрхангайн баруун хойд тал, Хулдын хойд, зүүн, Дэлгэрцогтын баруун хойд тал, Дэрэнгийн баруун хойд, зүүн тал, Цагаандэлгэрийн зүүн хэсэг, Сайнцагаан сумдын нутаг** буюу нийт нутгийн 35 хувь **даац 1-3 дахин хэтэрсэн** тул мал өвөлжилт, хаваржилтын нөхцөл хүндрэхээр байна(Зураг 15).


2017-2018 оны Дундговь аймгийн өвөл, хаврын бэлчээрийн даац, %
(багийн нутгаар)



Зураг 15. Бэлчээрийн даацын зураг, 2017 оны 8 дугаар сарын 22

Дундговь аймгийн дүнгээр 2018-2019 оны өвөл, хаврын бэлчээрийн даац **15% орчим** %бэлчээрийн нөөцтэй, **30% гаруй** бэлчээр хүрэлцээтэй учир мал өвөлжилт хаваржилт хэвийн байх боломжтой, харин нутгийн **55%** нь өөрийн сумын нутагт мал сүргээ онд оруулах бэлчээрийн боломж муу гарсан байна.

Хулд сумын хойд хэсэг бэлчээрийн даац **3-5 дахин хэтэрч** гарсан, **Дэлгэрхангай, Өндөршил, Гурвансайхан сумдын зүүн хэсэг, Говь-Угтаал, Эрдэнэдалай, Луус сумд, Адаацгийн хойд, урд тал, Дэлгэрцогтын баруун, урд тал, Сайхан-Овоо, Хулд, Дэрэн, Цагаандэлгэр сумдын баруун, зүүн тал, Сайнцагаан сумын зүүн талаас бусад нутаг** буюу нийт нутгийн 55 хувь **даац 1-3 дахин хэтэрсэн** тул мал өвөлжилт, хаваржилтын нөхцөл хүндэрч болзошгүй байна(Зураг 16).



Зураг 16. Бэлчээрийн даацын зураг, 2018 оны 8 дугаар сарын 24


2.5. УУЛ УУРХАЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаарх мэдээлэл

2018 оны жилийн эхний байдлаар Дундговь аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл 13 сумын нутагт 95, хайгуулын тусгай зөвшөөрөл 15 сумын нутагт 136, нийт 231 тусгай зөвшөөрөл байгаа бөгөөд эдгээрийн талбайн хэмжээ 1,004.5 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 13,4 хувийг эзэлж байна.

№	Сумын нэр	Ашиглалтын тусгай зөвшөөрөл		Хайгуулын тусгай зөвшөөрөл		Бүгд	Талбайн хэмжээ Мян.га	Газар нутгийн хэдэн хувийг эзлэх
		тоо	Талбай Мян.га	тоо	Талбай Мян.га			
1	Дэлгэрцогт	-	-	2	60.9	2	60.9	0,9
2	Дэрэн	-	-	5	78	5	78	1,2
3	Говь-Угтаал	11	7.5	7	17.9	18	25.5	6,3
4	Цагаандэлгэр	3	4.6	6	11	9	15.6	9,0
5	Баянжаргалан	29	40.4	14	27.7	43	68.1	14,9
6	Өндөршил	7	40.9	21	169.9	28	210.8	45,1
7	Гурвансайхан	15	71.8	14	77.2	29	149.1	24,7
8	Өлзийт	9	62.2	29	159.9	38	222.1	9,6
9	Хулд	3	6	20	160.6	23	166.6	25,0
10	Луус	2	0.4	10	86	12	86.4	11,2
11	Дэлгэрхангай	18	8.5	13	69.8	31	78.3	16,6
12	Сайхан-Овоо	1	1.4	1	3.7	2	5.1	1,2
13	Эрдэнэдалай	6	5.8	10	102.9	16	108.7	19,6
14	Сайнцагаан	4	3.2	3	8.9	7	12.1	1,6


15	Адаацаг	2	0.3	2	2	4	2.3	0.9
	Дүн /давхардсан/	110	156.4	157	848.1	267	1,004.5	14.1
	Давхардаагүй тоогоор	95	156.4	136	848.1	231	1,004.5	14.1




Ашиглалтын 95 тусгай зөвшөөрлийн 28 нь жоншны, 21 нь нүүрсний /7 орд/, 13 нь гөлтгөний /3 орд/, 12 нь барилгын материалын, 7 нь төмрийн, 8 нь алтны, 2 нь өнгөт металлын, 1 нь бал чулууны орд газар байна. Эдгээрийг 61 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагийн дотоодын хөрөнгө оруулалттай-40, хамтарсан хөрөнгө оруулалттай-8, гадаадын 100% хөрөнгө оруулалттай-13 байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид сумдаар

Ашигт малтмалын эзлэх талбайн харьцуулалт



/2018 онд хайгуулын үйл ажиллагаа явуулахаар 58 аж ахуйн нэгжийн БОМТөлөвлөгөө хянуулж, батлуулсан байна./




2.5.1. Эвдэрсэн газрын талбай

2018 онд зохион байгуулсан тооллогоор нийт 79 газрын 613.9 га эвдэрсэн газрын талбайн 17 хувь буюу 100.4 га талбай нь нөхөн сэргээх эзэн холбогдогч тодорхойгүй, үлдсэн 80 гаруй хувь буюу 513.5 га нь эзэн холбогдогчтой хэдий ч 3 хувьд талбайн эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан болон бичил уурхайн эрхлэгч иргэд байж болзошгүй байна.

Тус аймгийн хэмжээнд 2017 оноос хойш жоншны бичил уурхай эрхлэгч 54 нөхөрлөл үйл ажиллагаа эрхэлж, жоншны үндсэн ордыг техник хэрэгслээр олборлож байгаа явдал нь маш их эрсдэлтэй бөгөөд байгаль орчинд хор хөнөөл учруулж, газрын хэвлийд 60-70м гүн ангал, хавцал үүсч нөхөн сэргээлтийг нийт олборлолтын талбайн 40 орчим хувьд нь нөхөн сэргээлт хийсэн нь хангалтгүй үзүүлэлт юм.

Мөн сүүлийн жилүүдэд үйл ажиллагаа явуулаагүй, тусгай зөвшөөрлийн талбайг харуул хяналтгүй орхисноос болж иргэд хууль бусаар олборлох зөрчил гарч эдгээр ААНэгжүүдийн талбай эзэнгүй мэт орхигдсон байдалтай байгаа нь эвдэрсэн газрыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

Нийт эвдэрсэн газрын талбай
/сумдаар/



2.5.2. Уул уурхайн нөхөн сэргээлт

Уул уурхайн ашиглалтын зориулалтаар эвдэгдсэн газарт хийсэн нөхөн сэргээлтийн ажил 2017-2018 онд Гурвансайхан, Цагаандэлгэр сумдад 8.107 га талбайд нөхөн сэргээлт хийж актаар хүлээж авсан. Баянжаргалан, Дэлгэрхангай, Өлзийт, Гурвансайхан сумдад нөхөн сэргээлтийн ажлууд хийгдэж байна.

2.6. УСНЫ НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

2.6.1 ГАДАРГЫН УСНЫ НӨӨЦ

Аймгийн хэмжээнд гадаргын ус буюу булаг, шанд, нуур тойром 140 байна. Гадаргын усны нөөц нь 0.12 км^3 байна. Сүүлийн 5-10 жилд 40 гаруй булаг шанд, нуур ширгээд байна. Гадаргын усны хатаж, ширгэсэн болон сэргэсэн эх үүсвэрийг сумдаар нь авч үзвэл, Сайхан-Овоо, Баянжаргалан сумдад гадаргын усны эх үүсвэр хамгийн их хатаж, ширгэсэн бол Дэлгэрцогт сумдад сэргэсэн эх үүсвэрийн тоо их байна. 2017 онд ширгэсэн гадаргын эх үүсвэр 6, сэргэсэн эх үүсвэр булаг шанд цөөрөм 14, 2018 онд ширгэсэн эх үүсвэр 2, сэргэсэн эх үүсвэр булаг шанд, гол горхи, нуур цөөрөм 17 байна.

Онгийн гол. Хангайн нурууны зүүн өвөр хажуугийн далайн түвшнээс 2570 м өндөрт орших Ногоон нуураас эх авч Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутаг дахь Улаан нуурт цутгах 403 км урт гол 54 км нь Сайхан-Овоо, Дэлгэрхангай сумын нутгийг дамжина. Гандуу жил Дэлгэрхангай сумын нутаг дахь Хошуу хурлын хүрээ хавьд сэвсгэр хөрсөнд шургана. Хуртайд усны түвшин дээшилж урсгалын хурд нэмэгдэж адагтаа хүрнэ. 11-р сард хөлдөж дараа жилийн 4-р сард гэснэ. Бараг харзлахгүй. Хөвөө гольдролын хөндийд дэрс харгана элбэг бий. Усны химийн

найрлага нь гидрокарбонатын бүлэгт багтана. Говь руу очдог гуравхан голын нэг Онгийн гол Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймгийн сумын нутгийг дамжин хүн, малын ундаа болсоор ирсэн.



Онги голын усны төлөв байдлын мэдээлэл
2017 он

Түвшний хэмжилт хийсэн хоногоор тооцож дунджийг тооцвол 115 см буюу гол тасралт ихтэй усны түвшин маш бага байсан.

2018 он

Жилийн түвшин хэмжигдсэнээр тооцсон дундаж 119 см 8-9 сард усны түвшин их үертэй хоногийн тоо олон байсан.

2.6.2. Газрын доорх усны нөөц

Газрын доорх усны нөөц нь 0.08 км^3 байна. Газрын доорх уст цэгийн тоо 3791 болоод байна.

2.6.3. Усны нөөцийн хамгаалалт

Одоогийн байдлаар нийт 116 булгаас 50 орчим булгийн эхийг хашиж хамгаалаад байна.

2008 оноос эхлэн булгийн эхийг хашиж хамгаалах ажил улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байсан ч сүүлийн жилүүдэд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал буюу орон нутгийн төсвийн хөрөнгөөр жил бүр булгийн эхийг хаших хамгаалах ажлыг гүйцэтгэдэг. Аймгийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хооронд 2017, 2018 онуудад Байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний дагуу Сайхан-Овоо сумын “Ширээгийн булаг”, Дэлгэрцогт сумын “Талын булаг”, “Үүдийн



булаг", "Баянгийн булаг", Баянжаргалан сумын "Өөхий булаг", Сайнцагаан сумын "Тогоогийн рашаан"-ыг тус тус хашиж хамгаалж сэргээсэн байна.



Бүсийн тоо - 116



Хамсан булаг - 50



Сүм хөх бүрдийн нуурыг нөхөн сэргээв.

2016 онд Байгалийн үзэсгэлэнт “Сүм хөх бүрд”-ийн нуурыг нөхөн сэргээж, аялал жуулчлалын цогцолбор болгон хөгжүүлэх зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн 2.3 тэрбум төгрөгийн хөрөнгөөр бүтээн байгуулалтын ажлыг “Санжат” ХХК-аар гүйцэтгүүлж, гүний худаг гаргах, нуур тэжээх шугам хоолой татах, усан завины суваг байгуулах ажлыг хийв. Нуурын дотор талд усан завины суваг байгуулж уг сувгийг байгалийн чулуугаар доторлосон. Нуурын наад эрэгт үйлчилгээний барилга, сүмийн балгасны зүүн хойно Музейн барилгыг тус тус бариулсан. 2017 онд Сүм хөх бүрдийн аялал жуулчлалын цогцолбороор дотоодын 2500, гадаадын 300 орчим аялагчид үйлчлүүлсэн байна. 2018 онд дотоодын 560 жуулчид үйлчлүүлсэн байна.



2.6.4. Усны нөөцийн ашиглалт

Усны тухай хуулийн дагуу 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны газар гаргаж байна.

Ус ашиглуулах дүгнэлт гаргуулсан аж ахуйн нэгж, ирээдийн тоо, хэрэглэсэн ашигласан усны хэмжээг харуулбал:

Он	Аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Ашиглаж байгаа усны эх үүсвэр	Нийт ашиглах усны хэмжээ м ³ /жилд	Төлбөр ногдуулсан усны хэмжээ м ³ /жилд	Усны нөөц ашигласны төлбөр төг
2017	17	Газрын доорх ус	19825.85	13504	31534656

2018	16	Газрын доорх ус	20917.65	18263	16325010
------	----	--------------------	----------	-------	----------

Нийт ашигласан усны хэмжээ 2018 онд 5.05 сая м³ байна. Үүнээс хүн амын унд ахуйн хэрэглээнд 0.36 сая м³, мал аж ахуйд 4.53 сая м³, уул уурхайд 0.02 сая м³, ногоон байгууламжид 0.14 сая м³ тус тус ашигласан байна. Энэ нь нийт газрын доорх усны нөөцийн 6.31%-ийг эзэлж байна.

Усны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэхь заалтын дагуу иргэн, ААН-д худаг гаргах зөвшөөрлийг олгон ажиллаж байна.

2018 онд аймгийн хэмжээнд нийт 34 гүн өрмийн худгийг шинээр 365,5 сая төгрөгөөр, 39 энгийн уурхайн худгийг 79,0 сая төгрөгөөр сэргээн засварлаж нийт 51000 га бэлчээрийг усжуулж, бэлчээр усжуулалт өнгөрсөн оноос 3%-иар нэмэгдсэн.

2018 онд иргэд, малчид өөрийн хөрөнгөөр өмчлөлийн газартаа гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор гүн өрмийн худгийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж байна. Шинээр гаргаж байгаа инженерийн хийцтэй гүн өрмийн 16 худагт зөвшөөрөл олгож, техникийн паспортыг баталгаажуулж мэдээллийн санд оруулав.

Аймгийн хэмжээнд иргэдэд унд ахуйн зориулалтаар 42 өрөмдмөл худгаас ус түгээж байна. Үүний 13 худагт эрүүл ахуйн бүс тогтоосон.

2.7. ОЙН НӨӨЦ, ОЙН НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

2.7.1. ОЙН НӨӨЦ

Ойн сангийн газарт байгалийн болон таримал ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавьж өвчинд нэрвэгдсэн ойн талбай, түүнчлэн ойн захаас гадагш 100 метр хүртэлх газар, тарьц суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай тус тус хамаарна.

Дундговь аймгийн Өлзийт сумын 32759 га заган ой бүхий талбай нь ойн сан бүхий газарт хамаарч, тус ойн сангийн 20683 га талбай нь Загийн усны байгалийн нөөц газарт хамаарч улсын тусгай хамгаалалттай газарт ордог.

Дундговь аймагт ойн зохион байгуулалтын ажлыг мэргэжлийн байгууллага 2 удаа хийж гүйцэтгэсэн.


- 2007 онд ойн зохион байгуулалтын ажлаар 58 мянган га талбай ойн сангийн нөөцтэй.

/Ой хайгуул судалгааны төв/

- 2015 онд 32759 га талбай ойн сангийн нөөцтэй гэж тоологдсон. / “Денс форист” ХХК/ зөрүү 25255

Ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбай 13075 га талбайгаар, ойгоор бүрхэгдээгүй талбай 12169 га талбайгаар тус тус багасаж гарснаар ойн талбайн дүн нийтдээ 25255 га талбайгаар багасаж гарсан үзүүлэлттэй байна.

Ойн сангийн талбай	Газрын төрөл	2015 он	2007 он	Зөрүү
Ойгоор бүрхэгдсэн	Байгалийн ой /заг/	16793	19187	-2394
	Бут, сөөг /сухай/	16	10751	-10735
	Таримал	43		43
	Дүн	16852	29938	-13086
Ойгоор бүрхэгдээгүй	Тармаг	14953	28028	-13075
	Ойжих	954		954
	Ойжуулсан		48	-48
	Дүн	15907	28076	-12169
	Нийт дүн	32759	58014	-25255



Говийн бүс нь цаг уурын хатуу ширүүн нөхцөлтэй тул ургамлын төрөл зүйл цөөн, заг болон модлог ургамал тачир сийрэг ургах тул ойн сангийн газрын төрөл цөөн байна. Өлзийт сумын заган ойн сангийн талбайг газрын төрлөөр ангилан хэсэглэл тус бүрээр гаргаж харуулбал:

Ойн сангийн талбайн газрын төрлийн ангилал

Хэсэглэл	Ойгоор бүрхэгдсэн			Ойгоор бүрхэгдээгүй				Ойн талбайн дүн
	Байгалийн ой	Сөөг	Таримал ой	Дүн	Тармаг мод	Ойжих талбай	Дүн	
Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүсийн ой – Байгалийн нөөц газар								
2	2326	6	43	2375	3784		3784	6159
4	3511	3		3514	1341	954	2295	5809
5	5312			5312	3403		3403	8715
дүн	11149	9	43	11201	8528	954	9482	20683
Аж ахуйн төрөл: Хамгаалалтын бүсийн ой – Орон нутгийн тусгай хамгаалалттай газар								
1	2982			2982	4069		4069	7051
3	2662	7		2669	2356		2356	5025
дүн	5644	7		5651	6425		6425	12076
Нийт дүн	16793	16	43	16852	14953	954	15907	32759

Өлзийт сумын заган ойн сангийн нийт талбай 32759 га талбай байгаагаас 16852 га буюу 51.4% нь ойгоор бүрхэгдсэн талбай, 15907 га буюу 48.6% нь ойгоор

бүрхэгдээгүй талбай эзэлж байна. Ойгоор бүрхэгдсэн талбайн 16793 га буюу 99.64%-ийг байгалийн заган ой 16 га буюу 0.09%-ийг сөөг (сухай), 43 га буюу 0.25%-ийг таримал заг, ойгоор бүрхэгдээгүй талбайн 14953 га буюу 94%-ийг тармаг заг, 954 га буюу 6%-ийг ойжих талбай тус тус эзэлж байна.

Ойн сангийн талбайг сумын нийт газар нутагтай харьцуулбал 2.1%-ийг ойн сан бүхий талбай эзэлж байна. Өлзийт сумын байгалийн ойг бүрдүүлэгч гол мод нь заг бөгөөд сухай бага хувийг эзэлж байна. Дэлхий нийтийг хамарсан байгаль цаг уурын дулааралтай холбоотойгоор жилд орох хур тунадасны хэмжээ багассанаас заган ой хатаж хуурайшин сийрэгжихийн зэрэгцээ загийн салмаа нь мал амьтны чухал тэжээлийн нэг болдог тул шинэ залуу загийн өсвөр ургац, загийн салмааг идэж сүйтгэн түүний нөхөн сэргэх явцад саад учруулдаг.

2.7.2. Ойн нөөцийн хамгаалалт

Өлзийт сумын заган ойн сангийн 20683 га талбайг багтаан нийтдээ 273571 га талбайг “Загийн усны байгалийн нөөц газар”-ыг УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авчээ. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу тус байгалийн нөөц газарт байгаль хамгаалагч 2007 оноос хойш томилон ажиллуулж байна. Үүнээс өмнө хамгаалалтыг Өлзийт сум хариуцаж байв.

Загийн усны байгалийн нөөц газар нь Загийн усны хоолой дагуух газрыг хамрах ба хоолой дагуудаа хужир мараа, шал тойром, заган ой, довцог, элсэн манхан хослон орших учраас ландшафтын олон хэв шинж бүхий экологийн өвөрмөц орчныг үүсгэдэг. Загийн усны байгалийн нөөц газар нь заган ойн тархалтын зүүн талын хамгийн хойт цэг болдог ба хамгийн залуу, нөхөн ургалт сайтай хэдий ч аж ахуйн хэрэгцээнд зориулан түүх, устгах явдал мэр сэр байгааг харгалзан загийг хамгаалах, нөхөн ургах нөхцлийг бүрдүүлэх, зүй зохистой ашиглах зорилгоор байгалийн нөөц газар болгожээ. Монгол орны хар сүүлт зээрийн тархалтын хамгийн хойд, цагаан зээрийн тархалтын баруун хязгаар нутаг юм.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар модлог, бутлаг /бут, шаваг, заг, загасгал/ ургамлыг хамгаалах, түлшинд хэрэглэхгүй байх тогтоолыг 2008 онд гарган мөрдөж байна.

2.7.3. Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2005-2018 онд 12 суманд 140,9 га талбайд 76094 мод сөөг тарьж ургалтын хувь 80.8%-тай ургав.

Орон нутгийн төсвөөр 2009-2018 онд 12 суманд 110 га талбайд 67630 ширхэг мод сөөг тарьж 79.8 хувьтай ургав.

Аймгийн хэмжээнд нийтдээ 250.9 га, 143724 ширхэг мод, бут сөөг тарьж ургуулж ногоон байгууламжийг нэмэгдүүлээд байна.



Бусад эх үүсвэрээс. БНСУ-ын Гуяан хот, Мандалговь хот 2009 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, 10 жилийн хугацаанд 100 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг эхлүүлсэн. 2009-2018 оны байдлаар 79 га-д 84399 мод тарьж, ургалтын хувь 70%-тай байна. Хамтын ажиллагааны хүрээнд Мандалговь хотын ЕБСургуулиуд, ААНэгж, байгууллагын албан хаагчид жил бүр ойжуулалтын бэлтгэл ажилд оролцож байна.





“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” аян. 2010 оноос хойш Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг аймгийн хэмжээнд жил бүр зохион байгуулдаг. 2017-2018 онуудад тус арга хэмжээг Сайнцагаан, Луус, Гурвансайхан сумдад зохион байгуулав. 2010-2018 онуудад аймгийн хэмжээнд “Бүх нийтээр мод тарих өдөр” арга хэмжээнд 961 аж ахуйн нэгж байгууллагын 23466 иргэн 120.02 сая төгрөгийн хөрөнгөөр нийт 132748 ширхэг мод тарьсан байна.





Мод үржүүлэг. 2018 онд БОАЖЯам Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газарт 4,0 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайгаас төв суурин газрын ногоон байгууламжинд нийлүүлэх боломжтой стандартын шаардлага хангахуйц 13000 ширхэг хайлаас, 580 ширхэг улиас, 1800 ширхэг шар хуайс, 800 ширхэг улаан сухай, 200 ширхэг үхрийн нүд, 300 ширхэг чацаргана, 200 ширхэг голт бор зэргийг гарган бэлтгэсэн. Иргэн, ААН байгууллагуудад 12982 ширхэг хайлаас, 422 ширхэг улиас, 2035 ширхэг шар хуайс, 350 ширхэг улаан сухай, 8 ширхэг үхрийн нүд, 288 ширхэг чацаргана, 121 ширхэг


голт бор, 9 ширхэг монос, 13 ширхэг агч, бургас 20 нийт 16248 ширхэг суулгац нийлүүлсэн байна. Тарьц суулгацны нийлүүлэлт өмнө жилээс 21%-иар нэмэгдсэн.



2.8. ДУНДГОВЬ АЙМГИЙН УРГАМЛЫН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Ургамлын нэгдсэн тооллого, судалгааг 2018 онд “Эко үйлчилгээ” ТББ-аар гүйцэтгүүлэв.


Дундговь аймгийн нутаг дэвсгэр нь ургамал-газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог болон Дундад Халхын хээрийн тойргийн заагт (Өлзийхутаг, 1985), ургамалжлын бүс, бүслүүрийн хувьд хуурай хээр ба цөлийн хээрийн шилжилтийн бүс болох цөлжүү хээрийн дэд бүсэд (Түвшинтогтох, 2014) оршино (Зураг 1, 2).



Манай орны нутаг дэвсгэр байгалийн 6 бүс бүслүүрт хуваагдана (Зураг 3). Дундговь аймгийн хувьд нутаг дэвсгэр нь харгана бүхий жижиг дэгнүүлт үетэн-алаг өвс-хялганат жинхэнэ хуурай хээрийн хэв шинжийг илэрхийлдэг.

Цөлөрхөг хээр нь тус аймгийн өмнөт хэсгийг эзэлж байна. Монгол өвс-хазаар өвс-таанат бүлгэмдэл гол төлөөлөгч болдог. Тусгаг бүрхэц нь 20 хувь, дэрсэн толботой, 100 м²-д монгол өвс, хазаар өвс, таана, хөмөл, арзгар согсоот, торгомсог хэрээн хошуу, агь зэрэг 8-9 зүйл ургамалтай.

Дэрс, дэрст-бударганат хотгор хөндий нь Дундговь аймгийн нийт нутгаар алаг цоог тохиолдоно. Дэрс бүхий бударгана-таанат, дэрст, дэрс-хиагт, бэлчээрийн ургамлын тусгаг бүрхэц 10-15 хувь, 100 м² талбайд 10-17 зүйл ургамалтай.



Зураг 3. Монгол орны байгалийн бүс бүслүүр

Дундговь аймаг нь д.т.д. 1250-1700 метрийн өндөрт өргөгдсөн хойт хэсгээр Монгол Дагуурын уулын ойт хээрийн хэв шинж бага зэрэг нөлөөлсөн хээрийн хэвшил, өмнөд хэсгээр цөлөрхөг хээрийн нөлөө орсон болон зүүн, зүүн урд хэсгээр бэсрэг уулс, ухаа гүвээ толгодын ландшафттай нийтдээ тал хөндий, хотос хонхордуу газар зонхилон оршино.

Ургамалжилтын хувьд ерөнхийдөө толгодын ар хажуу хэсгээр харгана-алаг өвс ургамлын бүлгэмдэлтэй, харин тал хөндийн хэсгээр маш сийрэг алаг өвст, хотос хонхроор дэрс-хиагт, дэрс-улалжит хээрийн ургамалжил зонхилж, ихэнх хэсэг нь ургамалжлын ангиллаар хээрийн бүсийн хээр, цөлөрхөг хээрийн төлөөлөгч оролцсон бөгөөд дараах ургамалжилтын бүлгэмдэлдээ тэмдэглэгдсэн.

Тус аймгийн газар нутаг нь дараах ургамал бүлгэмдэл ургана. Үүнд:


- Дундад Халхын хуурай хээрийн бүсийн элсэрхэг хүрэн хөрсөнд ургах Крыловын хялгана, дэрвээн хазаар өвс, ботууль-жижиг дэгнүүлт үетэн- харганат болон ботууль-хялганат хээр болно (Зураг 6).



Зураг 6. Хялгана - жижиг дэгнүүлт үетэн - харганат болон
Хазаар өвс - хялганат хээр

Энэ нь хуурай хээрийн бүсийн өмнөд хэсгийн хүрэн хөрсөнд ургах харгана (алтан харгана - *Caragana leucophloea*, тарваган харгана - *Caragana pygmaea*) бүхий жижиг дэгнүүлт үетэн- хялгана- таанат (зүүнгарын хазаар өвс - *Cleistogenes soongarica*, клеменцийн хялгана - *Stipa klemenzii*, хөмөл - *Allium mongolicum*) эвшил зонхилон ургана.

Дундад Халхын хээрт хамаарах зарим хэсэгт говийн бэсрэг уул толгодын хоорондох элсэрхэг хүрэн болон хар хүрэн хөрстэй газар хазаар өвс- жижиг дэгнүүлт үетэн- агьт болон хялгана- агьт хээр бий. Үүнд: Монголын төв хэсгийн клеменцийн хялгана - *Stipa klemenzii*, өлчир шарилж - *Artemisia frigida*, дэгнүүлт шарилж - *A. caespitosa*, алтан харгана - *Caragana leucophloea*, тарваган харгана - *Caragana pygmaea* оролцсон, дэрвээн хазаар өвс - *Cleistogenes squarrosa* бүхий жинхэнэ хуурай хээр оршино (Зураг 7).



Мөн **Дорноговийн** цөлөрхөг хээрийн тойргийн тэгш өндөрлөг, бэсрэг уулсын хайргархаг, элсэрхэг бор хөрсөнд ургах баглуур- таана- хялганат (сайрын хялгана - *Stipa glareosa*, говийн хялгана - *S. gobica*, таана - *Allium polyrrhizum*, ахар навчит баглуур - *Anabasis brevifolia*) хээр өмнөт хэсэгт зонхилно (Зураг 8).

Тус нутгийн хойноос зүүн өмнөд хэсгийг дагаж хуурай хээрийн дэгнүүлт үетэнт, хялгана-жигж дэгнүүлт үетэнт, хялгана-агьт хээр тааралдаж байхад, нутгийн зүүн хойт хэсэгт сайр чулуурхаг хар хүрэн, хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс-хялганат хээр, өмнөд хэсгээр говийн бор хөрстэй хялгана-хазаар өвст, хялгана-таана-баглуурт цөлөрхөг хээр илэрдэг онцлогтой.

ДУНДГОВЬ АЙМГИЙН УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН БҮРДЭЛ

Монгол орны ургамал-газарзүйн Дундад Халх, Дорноговийн тойргуудын хээрийн бүсийн тодорхой газар нутгаар буюу Дундговь аймагт судалгаа явуулсан болон урьд жилүүдийн хийсэн судалгаа ургамлын цуглуулга, бичиглэлийг харьцуулан боловсруулж 39 овогт хамаарах 123 төрлийн 202 зүйл ургамал бүртгэв. Энэ нь ургамлын судалгааг ургамал ургалтын үеэс хожуу хийсэнтэй холбоотой байж болох юм. Эдгээр бүртгэсэн зүйл ургамлын дотор **НЭН ХОВОР 6 ЗҮЙЛ, ХОВОР 10 ЗҮЙЛ, ЭНДЕМИК 3 ЗҮЙЛ, СУБЭНДЕМИК УРГАМАЛ 13 ЗҮЙЛ, АШИГЛАЛТАНД**



ӨРТӨМТГИЙ АШИГТ УРГАМАЛ 27 ЗҮЙЛ УРГАМАЛ БАЙВ.

Дундговийн ургамлын аймагт Нангиад зээргэнэ - *Ephedra sinica* Stapf., алтан харгана - *Caragana leucophloea* Pojark., тарваган харгана - *Caragana pygmaea* (L.) DC., бариулт Бүйлэс - *Amygdalus pedunculata* Pall. зэрэг сөөг сөөгөнцөр; гялгар дэрс - *Achnatherum splendens* (Trin.) Nevski., говийн хялгана - *Stipa. gobica* Roshev., дэрвээн хазаар өвс – *Cleistogenes. squarrosa* (Trin.) Keng., саман ерхөг - *Agropyron cristatum* (L.) P.B., нангиад түнгэ - *Leymus chinensis* (Trin.) Tzvel., хөмөл - *Allium mongolicum* Regel., таана - *A. polyrrhizum* Turcz. ex Rgl., цагаалин цахилдаг - *Iris lacteal* Pall., олслиг халгай - *Urtica cannabina* L., шоргор лууль - *Chenopodium aristatum* L., цагаан лууль - *Ch. album* L., толгодын бударгана - *Salsola collina* Pall., маралнавчит гичгэнэ – *Potentilla tanacetifolia* Willd. ex Schlecht., ацан ажигана - *Stellaria dichotoma* L., сиверсийн шарилж – *A. sieversiana* Willd., ишгэн шарилж - *Artemisia dracunculus* L., өлчир шарилж – *A. frigida* Willd. зэрэг олон наст өвс зонхилон ургана.

Цаашид анхаарах асуудлууд:

- Дундговь аймагт ургаж буй нэн ховор, ховор ургамал нь байгаль экологийн хүчин зүйлээс хамаарч ховордож буй ургамал (Алтан бэрмэг, Сөөгөн шимэрс, Шивлээхэй зээргэнэ, Монгол догар г.м.), хүн амьтан нөлөөллөөс ховордож буй ургамал (Нангиад зээргэнэ, Толбот бэрээмэг, Ацан ажигана, Сибирь ерөндгөнө, г.м.) буй бөгөөд энэ бүс нутагт **нэн ховор 6 зүйл, ховор 10 зүйл, Эндемик 3 зүйл, Субэндемик ургамал 13 зүйл, ашиглалтанд өртөмтгий ашигт ургамал 27 зүйл ургамал** тохиолдоно.
- Ашигт (дотоодод хэрэглэгдэж байгаа эмийн болон экспортоор гаргаж байгаа) ургамлын нөөц ашигласны төлбөр, зөвшөөрөлгүй түүж бэлтгэсэн тохиолдолд экологи-эдийн засгийн үнэлгээний төлбөрийг яаралтай мөрдөж хэрэгжүүлэх.
- Дундговь аймгийн өвөрмөц ургамалжилт бүхий Их Адаацаг болон Их газрын чулуу, Бага газрын чулуунд "байгалийн цэцэгт ургамлын хүрээлэн" байгуулж тэнд байгалийн аясаар болон зориудаар зарим ургамлыг шилжүүлэн байршуулах, нутагшуулах улмаар нөхөн сэргээх.

Тархац нөөц багатай ашиглалтад өртөмхий ашигт ургамлыг улсын болон орон нутгийн хамгаалалтад авах, нэн ховор болон ховор ургамлыг үр болон тарималжуулах байдлаар үржүүлэн, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагатай байна.

2.9. АМЬТНЫ НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Амьтны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах чиглэлээр Амьтны тухай хууль болон холбогдох эрх зүйн акт мөрдөгдөж, Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах хөтөлбөр, Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр тус тус хэрэгжүүлж байна.

2.9.1. Амьтны нөөц

Монгол оронд 141 зүйл хөхтөн амьтан, 513 зүйл шувуу, 21 зүйл мөлхөгч, 6 зүйл хоёр нутагтан, 74 зүйл загас, 13 мянга гаруй зүйлийн сээр нуруугүйтэн бүртгэгдээд байна. Монгол орны амьтны аймгийн 2018 оны зүйлийн бүрдлийг 1998, 2016 оныхтой харьцуулж үзвэл зүйлийн тоо нь өссөн байна. Сүүлийн 20 гаруй жилийн судалгааны дүнгээр Монгол орны нэн ховор, ховор амьтан болох мазаалай баавгай багадаа 28, хүрэн байвгай 500, баданга хүдэр 6500, Төв Азийн минж 300, голын халиу 100, суусар булга 3500, цоохор ирвэс 900-1200, тахь 649, халиун буга 10000 орчим, хулан 10000, янгир 11000, аргаль 13000, молцог хандгай 16400, хавтгай тэмээ 800-1200, цаа буга 140-200, хар сүүлт 12000, зэрлэг гахай 35000, Монгол бөхөн 4000 гаруй тоо толгой тус тус байгаа бол цагаан зээр 3 сая орчим байна.

/Сүүлийн 10 жилд улсын хэмжээнд амьтны нэгдсэн тооллого, үнэлгээ хийгээгүй. Зөвхөн зарим амьтны тоо толгой, тархац, ашиглалтын нөөцийг монгол орны хэмжээгээр зохион байгуулсан байна./

Дундговь аймагт 12 зүйл хөхтөн амьтан, 23 зүйл шувуу, 2 зүйл мөлхөгч, 864 орчим зүйлийн шавьж бүртгэгдээд байна. Нэн ховор амьтнаас аргаль хонь, янгир ямаа, ховор амьтнаас хар сүүлт байна.

Үүнээс цагаан зээр 36336 тоо толгой, хар сүүлт 133 тоо толгой, аргаль хонь 1212 тоо толгой, янгир ямаа 771 тоо толгой, монгол тарвага 206 тоо толгой, саарал чоно 488 тоо толгой, шар үнэг 1152 тоо толгой, хярс 882 тоо толгой, монгол ногтруу 23593 тоо толгой, дагуур ятуу 25188 тоо толгой тархан нутаглаж байна.

“Эко үйлчилгээ” ТББайгууллагаар гүйцэтгүүлэн зарим амьтны тоо толгой, тархац, ашиглалтын нөөцийн судалгааг 2017 онд байгаль хамгаалах, нөхөн сэргээх, арга хэмжээний зардлаар хийв. Үүнд:

Цагаан зээр

Хээрийн судалгааны дүнд 2017 оны 6 сарын байдлаар **Дундговь аймгийн цагаан зээрийн тархац, байршил бүхий 41201,4 км² нутагт 36336.25 толгой цагаан зээр нэгж талбайд 11.5±9.9 нягтшилтайгаар** тархан нутаглаж байгааг тодруулав.

Өмнөх судлаачдын мэдээ баримт, судалгааны үр дүнд тулгуурлан үзвэл Дундговь аймгийн нэр бүхий сумдын нутагт хавар, зуны улиралд байрших цагаан зээрийн тоо толгойн хөдлөл зүйг тооцоолон үзвэл **хавар, зуны улиралд нэгж талбайд 11.5±9.9 бодгаль ногдох нягтшилтайгаар 24244-72672 тархан байрших** боломжтой байна.

Хар сүүлт

Дундговь аймгийн нутагт хар сүүлт нь таана-хөмөл-үетэнт, заг-бударганат, үетэн элдэв өвст зэрэг шүүслэг ургамал бүхий говийн уулсын бэлийн сайр, садарга, жижиг аараг толгод тэдгээрийн ам хөндий зонхилсон нэр бүхий газрыг тархан байршиж байна.

Аргаль хонь

Аргаль хонь нь аймгийн нутагт 85 сүрэгт хамрагдах 656 бодгаль тэмдэглэгдсэн бол харин аргаль хонины байршил бүхий Хулд, Луус, Говь-Угтаал зэрэг сумдын нэр бүхий газруудад 12 удаа ажиглалт хийхэд нэг ч аргаль хонь тохиолдоогүй байна.

Дундговь аймгийн нутагт аргаль хонины нөөцийг судалгаагаар тогтоогдсон аргаль хонины тоо толгойн байдлаас тооцоолон үзвэл **7521,21 км² нутагт тархан байршиж байна.**

Янгир ямаа

Дундговь аймгийн хэмжээнд янгир ямаа тархан байрших экологийн нөхцөл бүхий нутгийн хэмжээ 5003.1 км² (цөм байршил 1311.8 км²) буюу өмнөх судалгааны дүнгээс 27.3 хувиар илүү байгаа нь янгир ямааны тогтвортой байршил нутгийн хэмжээ нэмэгдэж буйг харуулна.

Дундговь аймгийн нутагт янгир ямааны нөөцийг судалгаагаар тогтоогдсон янгир ямааны тоо толгойн байдлаас тооцоолон үзвэл **2836.18 км² нутагт тархан байрших** боломжтой.

Монгол тарвага

2017 оны 5-6 сард хийсэн судалгааны дүнд үндэслэн үзвэл Дундговь аймгийн нутагт **674.7 км²** талбайд байршин амьдарч байна.

Судалгааны дүнгээс үзвэл Дундговь аймгийн нутаг дэвсгэрт 1788.84 км² талбайд тарвага тархан байрших экологийн нөхцөлтэй болох нь тогтоогдсон бөгөөд сэргээн нутагшуулсан болон судалгаагаар ажиглагдсан монгол тарваганы дүнд үндэслэн үзвэл 674.78 км² нутагт 740 толгой монгол тарвага идээшин нутагладаг нь тогтоогдлоо. Эдгээр монгол тарвага тархсан нутгийн талбайд 100 га буюу 1 км² талбайд дунджаар 10.9 тарвага ноогдох нягтшилтай байна.


Саарал чоно

Аймгийн хэмжээнд 27037.93 км² нутагт 488±32 толгой саарал чоно 1000 га-д 0.1 бодгаль ногдох нягтшилтай тархан амьдрах боломжтой байна. Сүүлийн жилүүдэд чонын тоо толгой өсөж байгаа бөгөөд саарал чонын малд халдах байдал тус аймгийн Гурвансайхан, Адаацаг, Өлзийт сумдын нутагт намрын улиралд ихээр нэмэгдэж байгаа талаар орон нутгийн иргэд мэдээлж байсан.

Шар үнэг

Аймгийн хэмжээнд 30830.66 км² нутагт 1152±29 толгой шар үнэг 1000 га-д 0.3 бодгаль ногдох нягтшилтай байна.

Хярс үнэг



Аймгийн хэмжээнд 37268.82 км² нутагт 882±130 толгой хярс үнэг 1000 га-д 0.2 бодгаль ногдох нягтшилтай байна.

Бор туулай

Хад чулуут бэсрэг уул, ухаа толгодын гуу жалга, дэрс-шавагт хотос, харганат хөндийд элбэг тохиолдоно. Судалгааны явцад 15 туулай ажиглагдсан.

Боролзон туулай

Аймгийн хэмжээнд 20751 ± 1547 боролзон туулай тархан байршиж байна

Монгол ногтруу

Аймгийн хэмжээнд 23593 ± 869 монгол ногтруу тархан байршиж байна.

Дагуур ятуу

Аймгийн хэмжээнд 25188 ± 754 дагуур ятуу тархан байршиж байна.

2.9.2. АН АМЬТАН АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Дундговь аймгийн хэмжээнд Баянжаргалан, Өлзийт, Гурвансайхан, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Өндөршил, Адаацаг зэрэг сумдад Агнуурын бүс нутгийг тогтоож, менежментийн төлөвлөгөөгөө батлуулсан.



Агнуурын бүс нутгийн судалгаа

№	Сумын нэр	Агнуурын бүсийн нэр	Менежмент хариуцагч ААНэгжийн нэр	Засаг даргатай гэрээ байгуулсан эсэх
1	2	3	8	13
1	Өлзийт	Уул алтаргана	Нью жуулчин турс ХХК	+
2	Баянжаргалан	Аргын хад, Шивээгийн уул	"Аанар" ХХК	+
3	Гурвансайхан	Гурвансайхан	Би Ти энд Ти Си ХХК	+
4	Сайхан-Овоо	Ахар уул	Натурал ай эн эн ХХК	+
5	Дэлгэрхангай	Улаан хад	Натурал ай эн эн ХХК	+

6	Өндөршил	Их уул	Би Ти энд Ти Си ХХК	+
7	Адаацаг	Их адаацгийн уул	Nomad Outdoor Travel ХХК	+
8	Өлзийт	Дэл хөнжил Баянхайрхан нөхөрлөл	"Аанар" ХХК	+

Агнуурын бүс нутаг дах хяналт шалгалт

2017 онд Аймгийн МХГазар, Баянжаргалан, Говь-Угтаал сумын ЗДТГазартай хамтран Говь-Угтаал, Гурвансайхан, Баянжаргалан сумын нутагт хууль бус ан агнуурын байдалд хяналт шалгалтыг хийв. Шалгалтаар Гурвансайхан сумын , Баянжаргалан сумын Аргын хад, Говь-Угтаал сумын Хараат, Их, Бага бичигт орчмын бүс нутаг хамрагдсан. Хяналт шалгалтын явцад Баянжаргалан сумын Аргатайн 3-р багт тус сумын 3 иргэн, Гурвансайхан сумын 1 иргэн тарвагыг замын хүнээс худалдан авсан нэрээр туламлан бэлтгэж байсан зөрчлийг илрүүлж холбогдох хуулийн дагуу 150000 төгрөгийн торгууль, 340000 төгрөгийн нөхөн төлбөр ногдууллаа. Уг тарвагыг улсын байцаагчийн актаар хураан авч Зооноз өвчин судлалын төвийн лабораторид хүргүүлэн, шинжилгээ хийлгэж зориулалтын цэгт устгаад байна. Үүнээс гадна Баянжаргалын сумын "Үхэгийн хад", Говь-Угтаал сумын "Ар сүүж" гэх газруудаас тарвага агнахаар тавьсан байсан 4 ш хавхыг хураан авлаа. Хууль бус ан агнууртай холбоотой сэрэмжлүүлэг, зөвлөмжийг хяналт шалгалтад хамрагдсан 10 иргэнд болон тус бүс нутгийн айл өрх, иргэдэд хүргүүлээ.


2018 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан удирдамжаар Дундговь аймгийн бүх сумдын нутаг дэвсгэрийг хамруулан тусгай зориулалтаар болон ахуйн зориулалтаар амьтан агнах, барих, худалдах, худалдан авсан иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил арга хэмжээ авч ажиллав. Удирдамжийн хүрээнд ангийн бүс нутаг бүхий 9 сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нар нийт 45 удаа эргүүл шалгалт хийж нийт 270 тээврийн хэрэгсэл, 287 иргэдийг хамруулан хяналт шалгалт хийсэн.

2016-2018 ОНД АГНАСАН АН ТОО ТОЛГОЙ, ТӨЛБӨР ХУРААМЖИЙН ОРЛОГО

№	Сум	Агнасан амьтан	2016		2017		2018	
			Тоо	Төлбөр	Тоо	Төлбөр	Тоо	Төлбөр
1	Гурвансайхан	Аргаль	1	19.650.000	1	29,000,000	2	72,236,860
		Цагаан зээр	-	-	-	-	3	
2	Өлзийт	Аргаль	2	41.796.000	2	67.488.240	-	25,000,000
3	Баянжаргалан	Аргаль	1	20.000.000	1	46,400,000	2	57,346,000
		Тэх			2		1	
		Цагаан зээр	-	-	-	-	-	
4	Сайхан-Овоо	Тэх	1	4.036.000	2	11,188,659	2	12,909,128
		Цагаан зээр	-	-	-	-	5	
5	Дэлгэрхангай	Аргаль			1	35,360,068	1	35,803,976
		Тэх			1		1	
		Цагаан зээр	-	-	-	-	5	
6	Өндөршил	Аргал	-	-	-	-	2	56,958,280
	Нийт дүн			85.332.000		189,436,967		260,254,244

Ангийн орлого 2017 онд 189.9, 2018 онд 260.2 сая төгрөг орсон. Энэ орлогын 50-иас доошгүй % /байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1.энэ хуулийн

13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно/-ийг хуульд заасны дагуу санхүүжилт бий болох нөхцлийг бүрдүүлэн ажиллав.



Ангийн орлого 2017 оноос 38 %-иар өссөн.

Био техникийн арга хэмжээ. Агнуурын мэргэжлийн байгууллагууд Өлзийт сумын “Уул алтаргана”, Баянжаргалан сумын “Аргын хад” “Шивээгийн уул”, Гурвансайхан сумын “Гурвансайхан уул”, Сайхан-Овоо сумын “Ахар уул”, Дэлгэрхангай сумын “Улаан хад” зэрэг газруудад 1.950.000 төгрөгний зардал гарган өвс, хужир, мөс зэрэг биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Дээрх агнуурын бүс нутагт Их газрын чулуу БЦГХЗахиргаа, байгаль хамгаалагч, БОХУБайцаагч нар хяналт тавьж ажиллав.

Нөхөрлөл агнуурын бүсэд зохион байгуулсан ажил арга хэмжээний график



Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын сургалт, мэдээллийн төвд 2017, 2018 онуудад тус тус Дундговь аймгийн Байгалийн нөөцийн менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагаа болон агнуур зохион байгуулалтын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлыг хэлэлцэх, нэгдсэн ойлголтонд хүрэх чиглэлээр тайлангийн хурал зохион байгууллаа. Уг тайлангийн хуралд аймгийн БОАЖГазар, МХГазар, Баянжаргалан, Гурвансайхан, Өндөршил, Өлзийт, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Дэрэн сумдын БОХУБайцаагч, Байгаль хамгаалагч, Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн ахлагч, ААНэгжүүд оролцдог.

2.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН БАЙДАЛ.

Дундговь аймгийн хэмжээнд “Байгаль орчны эсрэг гэмт хэрэг”-ийн сүүлийн 5 жилийн байдлаар бүртгэгдсэн тохиолдол байхгүй. Харин хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн шинжтэй буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлд зааснаар хэрэг бүртгэл нээн шалгагдаж буй тохиолдол байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

3.БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДОЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨВ

3.1. АГААРЫН БОХИРДОЛ

Агаарын бохирдол:

БОНХСайдын 2014 оны А/181 тоот тушаалаар батлагдсан “Агаар орчны бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ыг үндэслэн жил бүр нам даралтын уурын зуухны судалгаа, агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг хийж байна. 2018 онд аймгийн хэмжээнд усан халаалтын 11кВт-100 кВт хүртэл 105 зуух, 0.1 мВт-аас дээш 20 зуух, айл өрхийн ердийн 4317 зуух, сайжруулсан 239 зуух, ханан пийшин 418тоологдож бүртгэгдэж, түлшний хэмнэлттэй сайжруулсан зуухны тоо 2017 оноос 8,1 хувиар өссөн.Мөн уурын зуухны олон жижиг яндангийн тоо багасаж, бага оврын нам даралтын уурын зуухны тоо 2017 оноос 3,8 хувиар буурсан нь шинээр 5 сум төвлөрсөн халаалтанд холбогдсонтой холбоотой үр дүн гарсан байна.

Журмын дагуу тоо бүртгэлд агаарын бохирдлын доорхи эх үүсвэрүүдийг хамруулан тоолсон байна. Үүнд:

- 10 кВт хүртэлх хүчин чадалтай зуух /гэр, байшин, төвлөрсөн халаалтанд холбогдоогүй жижиг аж ахуйн нэгж, үйлчилгээний газрууд /
- 11-100 кВт хүртэлх хүчин чадалтай усан халаалтын зуух
- 101 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон ус халаах зуух
- Авто тээврийн хэрэгсэл

10 кВт хүртэлх хүчин чадалтай зуух /Галлагаатай айл өрх/

Дундговь аймаг	Гэрийн зуухны тоо		Гэрийн зууханд хэрэглэсэн түлшний хэмжээ			Байшингийн зуухны тоо		Байшингийн зууханд хэрэглэсэн түлшний хэмжээ		
	ердийн	сайжруулсан	нүүрс, тн	мод, м³	Бусад	ердийн	сайжруулсан	нүүрс, тн	мод, м³	Бусад
Аймгийн хэмжээнд	3,599	199	12239	1895,3	6523	718	40	3993,3	565,1	2363,5
Сайнцагаан сум	1,913	126	7473	1760	1829	589	11	2188	515	535
Сумдын хэмжээнд	1,686	73	4766,3	135,3	4694	129	29	1805,3	50,1	1828,5

Байшингийн зуухны тоонд ханан пийшин, усан халаалтын ахуйн зуухыг оруулан тооцсон


Усан халаалтын 11кВт-100кВт хүчин чадалтай, Дулааны цахилгаан станц, уурын болон усан халаалтын зуух 101 кВт-аас дээш хүчин чадалтай зуух

101 кВт-аас дээш хүчин чадалтай зуухны тоо нүүрсний хэрэглээг хүснэгтээр харууллаа. Аймгийн хэмжээнд халаалтын улиралд ажилладаг 101 кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуухнууд бүгд хаягдал утааны тоос, үнс баригч төхөөрөмжгүй бөгөөд төрөл бүрийн гар хийцтэй технологийн хувьд хоцрогдсон, ашигт үйлийн коэффициент бага, нүүрсний зарцуулалт их, дутуу шаталт ихтэй бага, дунд оврын халаалтын болон ердийн зуух ихээр ашиглагддаг байна.

Агаарын бохирдлын эх үүсвэрийн 2018 оны нэгдсэн тоо бүртгэлийн дүнгээс түлшний хэмжээг хүснэгтээр харуулахад

№	Дундговь аймаг	Зуухны тоо	Жилд хэрэглэсэн түлшний хэмжээ		
			нүүрс, тн	мод, м³	Бусад
1	10 кВт хүртэлх хүчин чадалтай зуух /гэр, байшин, төвлөрсөн халаалтанд холбогдоогүй жижиг аж ахуйн нэгж, үйлчилгээний газрууд /	5058	16,232	2440,4	8886,5
2	11-100 кВт хүртэлх хүчин чадалтай усан халаалтын зуух	105	7096,5		
3	101 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон ус халаах зуух	20	25653		


Дундговь аймгийн төвлөрсөн халаалтын судалгаа



Автотээврийн хэрэгсэл


Аймгийн хэмжээнд 2018 онд нийт 10814 тээврийн хэрэгсэл тоологдож автомашины тоо өмнөх оноос 2791 машинаар нэмэгдсэн нь 2017 оноос 34% өссөн байгаа нь агаар бохирдуулагч NO2-ийн агууламжийг ихэсгэж байгаа юм.

/Аймгийн автотээврийн газраас тээврийн хэрэгслийн судалгааг 2018 оны 12 сарын байдлаар авсан/







Агаарын чанарын үзүүлэлтийг SO_2 /хүхэрлэг хий/ NO_2 /азотын давхар исэл/ гэсэн үндсэн 2 үзүүлэлтээр тогтмол хэмждэг ба хэмжилтийн дүнгээр Монгол улсын агаарын чанарын хүлцэх агууламжаас 8-60 дахин бага буюу хэвийн үзүүлэлттэй байна. Өмнөх оноос SO_2 -ийн хэмжээ багассан бол NO_2 -ийн хэмжээ өссөн нь автомашины тоо аймгийн хэмжээнд 34 хувиар өссөнтэй холбоотой юм.



Мэдээллийн эх сурвалж: Дундговь УЦУОШТөө

Орон нутаг дахь агаарын чанарыг хянах суурин харуулуудын 2018 оны дүнгээр хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж $3-35 \text{ мкг/м}^3$ -ийн хязгаарт хэлбэлзэж, агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас Баянхонгорт 1.8 дахин их, Даланзадгадад 1.1 дахин их байна. 2017 оны дүнтэй харьцуулахад хамгийн их бохирдолтой Баянхонгорт өөрчлөлтгүй, Даланзадгадад 2 мкг/м^3 -ээр буюу 8%-аар бага байна. Хүхэрлэг хийн жилийн дундаж агууламжийг 2017 онтой

харьцуулахад Алтай, Арвайхээр, Баруун-Урт, Дархан, Мандалговь, Өлгий, Цэцэрлэг, Чойбалсан, Эрдэнэтэд 13-63%-аар их байна.



Мэдээллийн эх сурвалж: Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он

2018 оны азотын давхар ислийн жилийн дундаж агууламжийг 2017 онтой харьцуулахад Алтай, Арвайхээр, Багануур, Булган, Мандалговь, Өлгий, Өндөрхаан, Сүхбаатар, Улиастай, Чойр, Эрдэнэтэд 2-71%-иар их, Баруун-Урт, Дархан, Зуунмод, Мөрөн, Улаангом, Ховд, Цэцэрлэг, Шарын голд 8-47%-иар бага байсан бол бусад суурин газруудад өмнөх оны түвшинд байна.

3.2. Хөрсний бохирдол

“Монголын байгаль орчин, аюулгүй байдлын төв” ТББ, БОАЖГ хамтран Дэлгэрцогт сумын нутагт хөрсөнд асгарсан техникийн тостой газар болон аймгийн төв Сайнцагаан сумын нутагт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжүүдийн болон айл өрхүүдийн ойролцоох хөрсний бохирдол бүхий 32 цэгүүдэд хүнд металлын агуулгыг хэмжих замаар бохирдлын түвшин, тархалтыг хэмжиж, уг үйл ажиллагааны тайланг 2018 оны 1-р улиралд нэгтгэж тайланг гаргасан. Дэлгэрцогт суманд техникийн тос асгарсан газрын бохирдол бүхий талбайд тугалга, зэс, цайр, хүнцэл гэх мэт хүнд металлууд стандартын зөвшөөрөх хэмжээнд байв. Сайнцагаан сумын

уурын зуухнууд, авто засварын цэгийн орчны хөрсөнд хэмжилт хийхэд цайр авто засвар, үйлчилгээний газрын хөрсөнд, хүнцэл уурын зуухнуудын орчны хөрсөнд стандартын зөвшөөрөх хэмжээг тус бүр давсан байгааг тогтоосон байна.

Мандалговь хотын үйлдвэрлэлийн бүсэд бохирдолтой талбай буюу хатуу хог хаягдлаас бохирдсон хэсэг 10га орчим талбай байгааг урьдчилсан байдлаар гаргасан. Уг бүсэд Сайнцагаан сумын хог хаягдлын төвлөрсөн цэг орсон байгаа нь бохирдолтой талбайн өсөлтөд шууд нөлөөлж байна. Сансарын зургийн мэдээг ашиглан бохирдолтой 10 цэгийн координатыг тогтоосон ба ENVI 4.7 программаар хөрсний зургийг гаргасан.

Судалгааны талбай, үр дүн-1

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын төвөөс Мандалговь чиглэлийн авто замын баруун талд сумын төвөөс 13 км зайд орших “Улаан худаг” хэмээх нэртэй газар тус бохирдолтой талбай байрлана (Зураг 5).

Анх 2013 оны 09 сард Мандалговь-Улаанбаатар хотын чиглэлд зорчиж байсан ASIO GREENTO маркийн УНЗ 88-38 Улсын дугаартай ачааны машины чиргүүл тус газарт унаснаас 21 тн орчим “техникийн ажилласан тос” газрын хөрсөнд алдагдсан байна. Тухайн газрын гадарга нь баруун хойноос баруун урагш налуу бөгөөд зүүн талаар авто замын далангаар хамгаалагдсан байна.

Осол гарсан үед буюу 2013 оны 09 сард Дундговь аймгийн Онцгой байдлын газар, Дэлгэрцогт сумын засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг хэд хэдэн удаа талбайд ажиллаж асгарсан тосыг цэвэрлэх (талбайд нүх ухаж булсан, мөн борооны усанд хөвсөн хэсгийг авч булсан), тосны хамрах хүрээг тэлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шат дараатайгаар авч ажилласан байна. Тухайн үед бохирдсон талбайн хэмжээг 50 м/кв буюу 1000 м урт, 1.5 м өргөн гэж тогтоосон байна.

Харин 2016 онд дээрх осол гаргасан компанийн зүгээс зарим хэсгүүдэд тос тархахаас урьдчилан сэргийлэх материал дэвссэн гэж байгаа хэдий ч тодорхой мэдээлэл байхгүй юм.



Асгарсан тос булсан газар



Асгарсан тос замын ховил дагаж урссан байдал

Хэмжилт судалгааны үр дүнгээс үзвэл хар тугалга (Pb)-ын агууламж 16.127 ± 3.2 , Хром (Cr)-ын агууламж 66.363 ± 4.4 , Зэс (Cu)-ийн агууламж 15.9 ± 2.3 , Цайр (Zn)-ын


агууламж 62.874 ± 7.4 буюу стандартын зөвшөөрөх хэмжээнд байна. Харин Хүнцэл (As)- ийн агууламж 6.2 ± 1.0 буюу стандартын зөвшөөрөх хэмжээг бага зэрэг давсан байна. Нийт 10 хэмжилтийн 40 хувьд нь стандартыг давсан байна.

Хүснэгт 1. Химийн бодисын агууламж /Дэлгэрцорт сум/

№	Pb	Cr	Cu	Zn	As
1	29.39	62	16	62.9	9
2	9	48.42	13	62.1	7
3	34.57	79.45	0	105.23	0
4	12	82.65	19	40.56	10
5	0	78.81	14	34.21	6
6	11	70.82	28	57.96	10
7	16	79.63	22	69.96	2
8	14	51.15	14	39.48	6
9	13	46	13	57.61	6
10	22.31	64.7	20	98.73	6
Хамгийн их агууламж	34.57	82.65	28	105.23	10
Бага агууламж	0	46	0	34.21	0
Дундаж	16.127	66.363	15.9	62.874	6.2
Стандарт алдаа (SE)	3.202068	4.443699	2.325941	7.49012	1.019804
Стандарт хазайлт (SD)	10.12583	14.05221	7.35527	23.68584	3.224903
Стандарт	100	150	100	300	6
Стандартаас давсан хувь (%)	0	0	0	0	40

Тос асгарсан газрын талбайн хэмжээ: 2013 онд тогтоосноор 50 м/кв буюу 0.5 га байсан бол 2017 оны 12 сарын 18-ний байдлаар 1.20 га орчим болж талбайн хэмжээ нэмэгдсэн байна. Мөн 2013 онд урт нь 1000 м, өргөн нь 1.5 м гэж тодорхойлсон байгаа бол бидний тогтоосноор урт нь 1000 м орчим, өргөн нь дунджаар 9-10 м болж нэмэгдсэн нь ажиглагдлаа (Зураг 5).

Зураг 3. Бохирдсон талбайн хэмжээ



Судалгааны талбай, үр дүн-2

Дундговь аймгийн Сайнцагаан сумын төвд нийт 22 цэгт хэмжилт судалгаа хийсэн байна. Үүнд: “Ган-Илч” ХХК-ийн уурын зуухны орчимд 5, “Говийн гал” ХХК-ийн уурын зуухны талбайд 5, “Авто засварын газар” 5, хоёрдогч түүхий эд авдаг цэгийн хашаанд 7 хэмжилт хийсэн байна (Зураг 6). Үүнээс хоёрдогч түүхий эд авдаг цэгийн орчим нь хэт өндөр бохирдолтой байгаа учир хэмжилтийн мэдээллийг тусад нь боловсруулсан болно.



Зураг 4. Хэмжилт хийсэн цэгийн байрлал



“Ган илч” ХХК-ний уурын зуух



Уурын зуухны үнс



“Говийн гал” ХХК-ний уурын зуух



Авто засварын газар



Ашигласан техникийн тос, масло

Зураг 5. Аж ахуйн нэгжүүдийн харагдах байдал

Хэмжилт, судалгааны үр дүн:

Хар тугалга (Pb)-ын агууламж 17.13933 ± 2.0 , Хром (Cr)-ын агууламж 66.98667 ± 5.5 , Зэс (Cu)-ийн агууламж 41.83667 ± 5.5 , Хүнцэл (As)-ийн агууламж 4.2 ± 1.13 буюу стандартын зөвшөөрөх хэмжээнд байна. Харин Цайр (Zn)-ын агууламж 122.59 ± 53.1 , буюу стандартын зөвшөөрөх хэмжээг бага зэрэг давсан байна. Нийт 15 хэмжилтийн 26.6 хувьд нь хүнцэл,

6.6 хувьд нь цайр стандартын зөвшөөрөх дээд хэмжээг тус тус давсан байна.

Хүснэгт 2. Химийн бодисын агууламж (Сайнцагаан сум)

№	Pb	Cr	Cu	Zn	As
Хамгийн их агууламж	31	140.92	74	812.76	13
Бага агууламж	1	13	11	24.02	0
Дундаж	17.13933	66.98667	41.83667	122.59	4.2
Стандарт алдаа (SE)	2.039388	8.733652	5.585154	53.17224	1.138922
Стандарт хазайлт (SD)	7.898517	33.82529	21.63121	205.9352	4.411025

Стандарт	100	150	100	300	6
Стандартаас давсан хувь (%)	0	0	0	6.6	26.6

Судалгааны талбай, үр дүн-3

Энэхүү судалгааны талбай нь Сайнцагаан сумын төвд байрлах хоёрдогч түүхий эд (хар төмөр, зэс, гууль гэх мэт) худалдаж авдаг хувь айлын өмчлөл бүхий хашаа юм. Байгаль хамгаалагч, байцаагчийн өгсөн мэдээгээр сүүлийн 10 гаруй жил үйл ажиллагаа явуулж байгаа болно. Харин 2017 оны 12 сарын 18-ний өдрийн байдлаар тус хашаанд багахан хэмжээний түүхий эд авсан байлаа. Бид хашааны дотор болон гадна талд нийт 7 цэгт хэмжилт судалгааг хийсэн болно.



Хоёрдогч түүхий эд авч буй хашаа Хоёрдогч түүхий эд
Зураг 9. Талбайн харагдах байдал (хоёрдогч түүхий эд авах цэг)

Хэмжилт, судалгааны үр дүн:

Хар тугалга (Pb)-ын агууламж 394.18 ± 273 , Хром (Cr)-ын агууламж 95.41 ± 20.7 , Зэс (Cu)-ийн агууламж 748.3 ± 611.4 , Хүнцэл (As)-ийн агууламж 14.5 ± 4.9 Цайр (Zn)-ын агууламж 477.4 ± 221.3 буюу стандартын зөвшөөрөх хэмжээг бүгд давсан байна. Нийт 7 хэмжилтийн 57.1 хувьд нь хар тугалга, 14.2 хувьд нь хром, 42.8 хувьд нь зэс, 57.1 хувьд нь хүнцэл, 42.8 хувьд нь цайр стандартын зөвшөөрөх дээд хэмжээг тус тус давсан байна.

Хэмжилтийн мэдээний стандарт алдаа, болон хазайл хэт өндөр байгаа нь зарим хэмжилт хийсэн цэгт металл (зэс, гууль, хар төмөр)-ын үлдэгдэл таарсан байх магадлалтай юм.

Хүснэгт 3. Химийн бодисын агууламж (Хоёрдогч түүхий эд авах цэг)

№	Pb	Cr	Cu	Zn	As
Хамгийн их агууламж	2018.22	203	4404.22	1681.83	35
Бага агууламж	46.43	49	26	43.84	0

Дундаж	394.1814	95.41429	748.0329	477.4214	14.57143
Стандарт алдаа (SE)	273.2876	20.70587	611.4612	221.3141	4.989785
Стандарт хазайлт (SD)	723.051	54.78259	1617.774	585.5421	13.20173
Стандарт	100	150	100	300	6
Стандартаас давсан хувь (%)	57.1	14.2	42.8	42.8	57.1

Судалгааны ажлын дүгнэлт

МОБАБ ТББ-ын судалгааны баг 2017 оны 12 сарын 18-ны өдөр Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутагт орших “Улаан худаг” нэртэй газар 2013 онд техникийн тос хөрсөнд асгарсан газар 10 хэмжилт, Сайнцагаан сумын төв буюу аймгийн төвийн Уурын зуух (2 уурын зуух тус бүрт нь 5), авто засвар, үйлчилгээний газар (5), хоёрдогч түүхий эд авдаг цэг (7) буюу нийт 32 цэгт хэмжилт хийж мэдээллийг талбай тус бүрээр боловсруулж үр дүнг харууллаа. Үүнээс товчхон дүгнэж үзвэл техникийн тос асгарсан газрын бохирдол бүхий талбайн хэмжээ анхны тодорхойлсноос 2 дахин нэмэгдсэн байна. Харин хар тугалга, зэс, цайр, хүнцэл гэх мэт хүнд металлууд стандартын зөвшөөрөх хэмжээнд байлаа.

Дараагийн бүлэг хэмжилт буюу Сайнцагаан сумын уурын зуухнууд, авто засварын цэгийн орчны хөрсөнд хэмжилт хийхэд цайр авто засвар, үйлчилгээний газрын хөрсөнд, хүнцэл уурын зуухнуудын орчны хөрсөнд стандартын зөвшөөрөх хэмжээг тус бүр давсан байна. Гэсэн хэдий ч хорттой, аюултай агууламжийн хэмжээнд байлаа.

Сумын төвд хоёрдогч түүхий эд авдаг айлын хашаанд хийсэн зарим хэмжилтэнд хар тугалга, зэс, цайр, хүнцлийн агууламж хэт өндөр буюу стандартын хорттой, аюултай агууламжийг ч давсан үзүүлэлттэй байгаа нь хэмжилтийн явцад металлын(зэс, гууль, хар төмөр) үлдэгдэл таарсан байх магадлалтай юм.

Дундговь аймгийн цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан тайланд тусгагдсанаар сонгогдсон цэгүүдэд хийдэг хэмжилтээр **Дундговь аймгийн** хөрсний хяналт шинжилгээний дүн мэдээг хөрсний чанарын MNS 5850:2008 стандарттай харьцуулахад цайрын агууламж “Говийн ирээдүй цогцолбор” цэгт 1.6 дахин, “Өлзий” цэгт 1.2 дахин, “ШТС-ын баруун хойно” цэгт 2.4 дахин, стронцийн агууламж “Цаг уурын хашаан дотор” цэгт 1.1 дахин их бусад хүнд металлуудын агууламж хэвийн байна.

3.3. Усны бохирдол

Сайхан-Овоо сумын Онги сайхан-Овоо усны харуулын 1 цэгт усны бохирдлыг шинжилж байна. 2017, 2018 онуудад Онги гол 3-р зэргийн буюу бага зэргийн бохирдолтой байсан. Харуулын цэг жилд 4-8 удаа удаа бодис, эрсдэлжилтийн хэмжилтийг хийдэг.

3.4. Хог хаягдал

Хог хаягдлын тухай хууль 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдөр шинэчлэн батлагдсантай холбогдуулан иргэдэд хог хаягдлын боловсрол олгох, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг үндэслэн Мандалговь хотын төвийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн гадна орчин, нийтийн эзэмшлийн гудамж талбайд зориулалтын ангилан ялгах хогийн сав байрлуулах, нийтийг хамарсан цэвэрлэгээний ажлыг тус тус зохион байгуулав.

“Дундговь аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр батлах тухай” аймгийн ИТХТэргүүлэгчдээр батлуулан, хөтөлбөр 88 хувьтай хэрэгжив.

2018 онд 15 суманд 3175.2 га талбайд 32667,5 тн хог хаягдлыг цэвэрлэж зайлуулсан ба нийтийн эдэлбэр газрын их цэвэрлэгээнд 3149 иргэн оролцож, 5000 гаруй иргэдэд хог хаягдлын хуулийн сурталчилгааг хийж, 32,741,000 төгрөгний төсөв улсын болон орон нутгийн төсвөөс зарцуулсан нь хог хаягдлын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулах иргэдийн оролцоо нэмэгдэх хандлагатайг харуулж байна.

Хог хаягдлын төвлөрсөн цэгт зайлуулсан хатуу хог хаягдлын хэмжээ



Аюултай хог хаягдал эрүүл мэнд, эмнэлгийн байгууллагаас жилд 70-80 тонн гарч, үүний 30 орчим хувийг зориулалтын байгууламжид шатааж байна.

3.5. Химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, тээвэрлэлт, хамгаалалтын байдалд тандалт судалгаа хийсэн ба тандалт судалгаанд хамрагдсан 32 объектод хийгдсэн.

18 сургууль, 7 эрүүл мэндийн төв, 5 лаборатори, 1 хортон шавьж устгал, 1 хими цэвэрлэгээнд химийн хорт бодис байсан бол 11 аж ахуйн нэгж байгууллагад химийн бодис илрээгүй. Давхардсан тоогоор 500 нэр төрлийн 163 кг, 123.18 литр химийн бодис хадгалагдаж байна. Мөн устгах шаардлагатай 236 нэр төрлийн 2832.4 кг, 12.2 литр химийн бодис байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

4.1. Салбарын эрх зүйн өнөөгийн байдал

ДУНДГОВЬ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эрхзүйн орчин



Аялал жуулчлалын тухай хууль 2000 онд батлагдсан. Уг хуулийн хүрээнд Аялал жуулчлалын байрны төрлийн үндсэн нэр томьёо зочид буудалд тавих ерөнхий шаардлага, жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага, авто замын дагуух үйлчилгээний цогцолбор, ангилал, ерөнхий шаардлага, Аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох журам, жуулчны авто тээврийн үйлчилгээний ерөнхий шаардлага зэрэг нийт 12 дүрэм, журам, стандартууд мөрдөгдөж байна.


Монгол улсын Засгийн газраас “2016–2025 онуудад Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, “Дундговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2016–2020” хэрэгжүүлж байна.

Дундговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын салбарын бодлогын хэрэгжилтийг хангаж, аялал жуулчлалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий бие даасан нэгж болох “Говийн шуранхай” аялал жуулчлалын холбоо 2014 онд байгуулагдсан.

2012-2018 онд хэрэгжүүлэх “Аймгийн аялал жуулчлалын стратеги төлөвлөгөө”-г аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллав. Аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөний хугацаа дуусч төлөвлөгөөний хэрэгжилт нийт 113 зорилтын хүрээнд 46 төсөл, арга хэмжээг хэрэгжихээс, 40.5%-тай байна.

2018 онд аялал жуулчлалын сурталчилгааг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын жуулчдад зориулсан гар утасны аппликейшныг англи, монгол хэл дээр “dundgovi province” нэрээр гаргав. Мөн англи, монгол хэл дээр аймгийн аялал жуулчлалын бүхий төрлийн мэдээллийг нэг дороос авах боломжтой <http://baigali.du.gov.mn/travel> вэб сайтыг ашиглалтанд оруулсан юм.





Жуулчин хүлээн авах хүчин чадал

Дундговь аймаг нь аялал жуулчлалын байршуулах хэрэгслийн хувьд 5 зочид буудал, 12 жуулчны бааз, 1 гэст хаус, 1 сувилал, 2 амралтын газар, 12 гэр буудал, 10 мотел үйл ажиллагаа явуулж байна. Тус аймгийн хувьд аялал жуулчлалын говийн бүсийн зангилаа бөгөөд монгол улсын аялал жуулчлалын гол чиглэлүүдэд байрладаг нь гадаадын жуулчдыг татах нөхцөл боломж юм. (Зураг 1)

Тус аймгийн байгалийн үзэсгэлэнт газрууд болох Цагаан суварга, Онгийн хийд, Бага газрын чулуу, Их газрын чулуу, Хайлаастын ам, Өөш манхан зэрэг газруудыг түшиглэн аялал жуулчлалын бааз, амралтын газрууд үйл ажиллагаа явуулдаг.

График 1.



2018 онд Дундговь аймагт **19540** гадаад, дотоодын жуулчид ирсэн бөгөөд үүнээс 14815 нь гадаадын жуулчид байна. 2017 онтой харьцуулахад гадаадын жуулчид 29,65%-иар, дотоодын жуулчид 35,38%-иар өссөн байна. Сүүлийн жилүүдэд Итали, Герман, Франц, Солонгос орны жуулчид хамгийн ихээр зорин ирдэг. (График 2)



Дундговь аймаг нь улс орондоо дуу хуурын өлгий нутаг төдийгүй адуу айргаараа алдаршсан аймаг юм. Уртын дуу, морин хуурыг сурталчлах ажлын хүрээнд Их газрын чулуу, Онгийн хийд, Сүм хөх бүрд гэсэн 3 газарт задгай театр байгуулсан аймаг билээ. Тэр ч утгаараа нутаг орныхоо онцлогийг харуулсан аялал жуулчлалын Уртын дуу, морин хуурын наадам, адуу, айрагны баяр, тэмээний баяр, малчны баяр зэрэг эвент үйл ажиллагааг зохион байгуулдаг билээ. Улсын хэмжээнд нүүдлийн соёл иргэншил, мал аж ахуйн зан заншилтай олон эвент үйл ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд тус аймгийн уртын дуу, морин хуурыг сурталчилсан эвент нь бусдаас онцлог юм. Энэхүү эвентийг цаашид жил бүр зохион байгуулж дотоод, гадаадын жуулчдад үзүүлснээр Монголыг сурталчлах аялал жуулчлалын томоохон брэнд бүтээгдэхүүн болно гэж үзэж байна. Мөн зохион байгуулагдаж буй эвентүүдэд нутгийн иргэдийн орлого олох, гар урлал, бэлэг дурсгалын зүйлс болон сүү, цагаан идээг зарж борлуулах боломжоор хангах шаардлагатай.

Д/д	Арга хэмжээний нэр	Хугацаа /Сар, өдөр/	Зохион байгуулагдах аймаг, сум	Зохион байгуулагч	Холбогдох утас, e-Мэйл хаяг
-----	--------------------	---------------------	--------------------------------	-------------------	-----------------------------

1.	“Малчны баяр – Ардын урлагийн наадам” арга хэмжээ	Жил бүр 2020.09.08 -09	“Онгийн хийд” байгалийн дурсгалт газар	Аймгийн ЗДТГ, Сайхан-Овоо сумын ЗДТГ, БОАЖГ Жуулчны баазууд “Говийн шуранхай” АЖХолбоо	89006844
2	“Айраг - Адуучны баяр” арга хэмжээ	Жил бүр 2020.08.22 - 23	“Бага газрын чулуу” Улсын тусгай хамгаалалттай газар	Аймгийн ЗДТГ, Адаацаг, Дэлгэрцогт сумын ЗДТГ, БОАЖГ, жуулчны баазууд Говийн шуранхай холбоо	89006844
3	“Их говийн тэмээ” арга хэмжээ	2020.09.26	“Цагаан суварга” байгалийн үзэсгэлэнт газар	Аймгийн ЗДТГ, Өлзийт сум ЗДТГ Жуулчны баазууд Говийн шуранхай холбоо	89006844
4	Уртын дуу, морин хуурын наадам	2 жил тутам 8 дугаар сард	Их газрын чулуу байгалийн цогцолборт газарт	Аймгийн ЗДТГ, Гурвансайхан, Говь-Угтаал сумын ЗДТГ БСУГ, БОАЖГ, Говийн шуранхай холбоо	89006844

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Дундговь аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг төлөвлөн хэрэгжүүлэх Мастер төлөвлөгөөг боловсруулж батлуулах, аялал жуулчлалын стандарт шаардлагуудыг сайжруулах “Гэр буудал” ажиллуулах журмын төслүүдийг боловсруулж батлуулах.

Жуулчдын ая тухтай аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Өлзийт сумын байгалийн үзэсгэлэнт Цагаан суварга, Дэлгэрцогт сумын Бага газрын чулуунд нэвтрэх цэг, био ОО, мэдээллийн самбар хийхээр төлөвлөөд байна. Ойрын хугацаанд сум орон нутагтай хамтран ажиллаж аялал жуулчлалын бүсүүдийн зорин очих газрын ая тухтай зорчих нөхцлийг бүрдүүлэх, байгаль орчны бохирдлыг бууруулах зорилтыг тавьж байна. Тус ажлын хүрээнд био ОО бий болгох, сандал сүүдрэвч, тасалбар хураамж бий болгож нэвтрэх цэгтэй болгосноор орон нутагт аялал жуулчлалаас олох орлого нэмэгдэх, олсон орлогоор тухайн газрыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Цаашид аймгийн аялал жуулчлалын бүс нутгууд болох Онгийн хийд, Бага газрын чулуу, Цагаан суварга, Их газрын чулуу зэрэг газруудад бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын цогцолбор төв болгон хөгжүүлэх зураг төсвийг боловсруулах, нөөц даацын судалгаа болон менежментийн төлөвлөгөөг хийж гүйцэтгэх шаардлагатай юм. Аялал жуулчлалын өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагыг хангах, улирлын хамаарлыг бууруулах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөрт хамрагдах шаардлагатай юм.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн зарцуулалт

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн хэрэгжилт 2017 онд орон нутгийн төсөвт 491141000 төгрөгний орлого хуримтлагдсан бөгөөд хуулийн 18.1-заасны дагуу 32828400 төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан байна.

2017 онд орон нутгийн төсөвт 498140100 төгрөгний орлого төвлөрснөөс 90409300 төгрөгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу
Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого, зарлага /2017-2018/

